

**ГАЗАР АШИГЛАЛТ,
БЭЛЧЭЭРИЙН
МЕНЕЖМЕНТ**

Григори А. Кеннетт

Улаанбаатар 1999

ГАЗАР АШИГЛАЛТ,
БЭЛЧЭЭРИЙН
МЕНЕЖМЕНТ
Григори А. Кеннетт

Улаанбаатар 1999 оны 11-р сар

Ерөнхий Тойм

Энэхүү төсөл нь Монголын говийн бүсийн бэлчээрийн газрын нөөц, түүний нөхцөл байдалд хээрийн судалгааны аргаар ажиглалт болон дүн шинжилгээ хийхээс бүрэлдэж байна. Төсөл нь Америкийн Нэгдсэн Улсын Олон Улсын Хөгжлийн Агентлаг / USAID/ - аас дэмжигдэн хэрэгжүүлж байгаа Говийн Бүсийн Эдийн Засгийг Хөгжүүлэх Санаачлага /Говийн Санаачилга/ төслийн хүрээнд хийгдсэн болно. Говьд нүүдлийн бэлчээр ашиглагчдын эдийн засгийн байдлыг сайжруулах стратегийг боловсруулж байгаа юм. Олон улсын зүгээс үзүүлж байгаа хэд хэдэн хүчин чармайлт, үйл ажиллагаанууд хамт Говийн Санаачилга - ийн ажилтнууд Говийн бэлчээрийн газар муудаж байгааг мэдэрч, ойлгож байгаа бөгөөд түүнийг сайжруулах нөөц бололцооны талаар эрэлт судалгаа хийж байна.

Энэхүү төслийн хээрийн судалгаа 1999 оны арваннэгдүгээр сард хийгдсэн. Говьд хийсэн 13 өдрийн хээрийн судалгаа нь Өмнөговь, Дундговь аймгуудын нутаг дахь бэлчээр болон холбогдох нөөцийг дахин судалж, тооцоолон үзсэн болно. Бид /Базаррагчаагийн Алтанцэцэг, Григори Кеннет/ нутгийн малчид болон орон нутгийн захиргааны мэргэжилтнүүдийг хамруулан бэлчээрийн менежментийн чиглэлээр нийтдээ дөрвөн семинар зохион байгууллаа. Эдгээр семинарууд дээр бэлчээрийн менежментийн үндсэн зарчмуудын талаар ярьж тайлбарлаж, түүнийг хэрэгжүүлэх явцад тарах амжилт, алдаа онооны талаар Америкийн Нэгдсэн Улсын бэлчээрийн менежментийг жишээ болгон танилцуулж, ярилцлаа. Түүнээс гадна семинар болгоноор байгалийн нөөцөд тулгараад байгаа асуудлуудыг тодорхойлж, цаашид тавих зорилтуудын ерөнхий санаа, дүр зургийг гаргасан. Яригдаж байгаа асуудлуудад семинарт оролцогч хүн бүрийг идэвхтэй оролцуулах үүднээс семинарыг идэвхжүүлэгч /participatory/ хэлбэрээр зохион байгуулсан болно. Эдгээр семинарууд нь нөөц ашиглалт ба бэлчээрийн нөхцлийн хоорондын уялдаа холбооны асуудлыг хөндөж ярилцсанаараа их ач холбогдолтой, амжилттай болсон. Ялангуяа семинарт оролцогчид говийн байгалийн бэлчээрийг бидний мэдэж байснаас маш өөрөөр, өнөөдөр бидний олж мэдсэнээс илүү баялаг, үр шимтэй болох талаар дүрслэн ярьж, тодорхойлж байлаа. Ихэнх оролцогчид бэлчээрийн нөөцийн багасалт, хомсдолыг дэлхийн цаг агаар дулаарсантай холбогдуулан тайлбарлаж байсан ба бэлчээр муудалтад бэлчээрийн менежментийн практик үйл ажиллагаа нөлөөлдөг гэдгийг дуртай дургүй байдлаар зөвхөн хүлээн зөвшөөрч байлаа.

Гэвч бидний хийсэн хээрийн судалгаа чухамдаа бэлчээр бүхэлдээ тахлагдсан болохыг харуулж байлаа. Энэхүү дүгнэлтийг зүгээр нэг цаг үрэхгүй гэсэн үүднээс яарч сандарч гаргаагүй болно. Бэлчээрийн тахлагдсан байдлын талаархи асуудлаар малчидтай харилцан ярилцах болгондоо бид бэлчээрийг маш өөдрөг байдлаар дахин үнэлж шалгаж явлаа. Гэсэн хэдий ч байгалийн өвс ургамлыг дэндүү их хэмжээгээр хэрэглэсэн, бут ургамал нь цаашдаа тогтвортой байдлаар нөхөн ургахгүй болтлоо тахлагдсан болон өвс ургамлын бүтцэд ихээхэн өөрчлөлт орж бэлчээрийн нөөц дуусч үгүй болох аюулд тулгараад байгааг бид олж тогтоосон. Бусад хэд хэдэн ажиглагчид ч /Бедунах, 1998; Хилбиг, 1995; Баруун ба Одгаард, 1996/ бэлчээрийг хэтрүүлэн ашигласан талаар тэмдэглэсэн байсан. Бэлчээрийн даацыг тооцоолон гаргадаг энгийн аргыг ашиглан бид тооцоо гаргахад Говийн бүсийн даац бараг 200 хувьд хүрсэн байсан. Нөөцийг ийнхүү ужигжсан хор хөнөөлтэй байдлаар хэтрүүлэн ашиглах нь эдийн засгийн болон экологийн хувьд муу үр дагавартай байдаг. Хөрсний элэгдэл, цөлжилтийн нэмэгдэл, хөрсний ус шингээх чадвар доройтож, муудах, амьд байгалийн оршин тогтнох орчин алдагдах, байгалийн ховор төрөл зүйл устаж үгүй болох зэрэг нь малын бэлчээр ашиглалтын өнөөгийн түвшингээс хамаарч үүдэн тарах байгаль орчны наад захын хор хохирлын хэдхэн тооны жишээнүүд болж байна.

Говийн бэлчээрийн өнөөгийн энэхүү байдал нь Хардины /1968/ -ны гаргаж тавьсан "Нийтийн эмгэнэл" гэдэгтэй адил төсөөтэй болж байна. Нийтийн эмгэнэл нь чөлөөт зах зээлийн бэлчээр ашиглалт нийт малчдад нээлттэй болно гэдэг таамаглалыг дэвшүүлсэн байна.

Малчин бүр өөрсдийн ашиг орлогыг нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлж байдаг бөгөөд үүний тулд сүргийн тоог нэмэгдүүлэх нь тэдэнд ашигтай гэж үздэг. Малын тоог өсгөх нь нийтийн бэлчээрийн тахлалтыг бий болгож, бэлчээрийг муудгадаг гэдгийг малчид хэдийгээр мэддэг ч гэсэн малынхаа тоо толгойг нэмэх нь тэдний хувьд орох ашиг орлогоо нэмэгдүүлэх гол арга зам юм гэж үздэг. Учир нь малаа өсгөн түүнийгээ борлуулах замаар олох ашиг орлого нь зөвхөн тухайн малчинд ноогдох бөгөөд харин бэлчээрийг хэтрүүлэн ашигласны улмаас үүсэх сөрөг үр дагаврыг нийт малчид дундаа хуваан хүртдэг байна. Энэхүү "Нийтийн эмгэнэл" гэдэг нь бэлчээрийн ашиглалтад хяналт тавьдаггүй, малчид нь харилцан солилцох гэдэг философийг дагадаг, улмаар уламжлалт бэлчээрийн газартаа бусад малчдыг малаа бэлчээрлүүлэхийг зөвшөөрдөг Монголын нөхцөлд их нийцэж таарч байгаа юм. Хувийн ашиг сонирхлоо ойлгон мэдэж авсан малчдын хувьд бэлчээрийн нөөц их хэмжээгээр багасаж, муудаж байгааг ухаарч мэдрэх нь удаашралтай байдаг.

Миний хувьд энэхүү Тайланд дэвшүүлсэн санал зөвлөмжүүд тийм амархан хэрэгжихгүй, тэр бүү хэл хэрэгжүүлэлтийн эхний үе шатанд ч амжилтанд хүрэхгүй гэдгийг мэдэж байна. Зах зээлийн эдийн засгийн сөрөг үр дагаврууд болон газар ашиглалтад тавих хяналт байхгүй байгаа байдлууд нь бэлчээрийн тахлалтын асуудлыг бий болгодог. Зөвлөлт засгийн нөлөөн дорхи захиргаадалтын үеийн эдийн засагт хөрөнгийн тоо хэмжээг тодорхой хязгаартай тогтоож байсан байна. Захиргаадалтын үеийн бэлчээр, бэлчээрийн газрын нөхцөл байдлыг хүчин чадал, даацаасаа доогуур хэмжээнд малжсан хэмээн тодохойлж ирсэн. Зах зээлийн эдийн засаг нь төрөөс олгох татаастай хамтраад ирэхлээрээ богино хугацаанд тустай байж болох боловч малчдыг нийтийн эзэмшлийн бэлчээрийн нөөцөө хамгаалах тал руу түлхэж өгдөггүй гэдэг нь нийтлэг үзэгдэл байдаг байна. Энэ байдал нь байнгын өөрчлөлт хөгжилтөнд тэнцвэртэй бус байдлаар байнга өртөж байдаг бэлчээрийн орчинтой уялдаад цаашдаа улам хүндрэлтэй болдог байна. Өнөөдөр бэлчээрийн газрын талын эрдэмтэн судлаачид малын тоо нь бэлчээрийн газрын нөхцөл байдалд нөлөөтэй гэж үзээд, малын тоог толгойг өсгөхийн ач холбогдлыг багасгах тал дээр ажиллаж байна. /Тодруулах нь: та малын тоо нь бэлчээрийн нөхцөл байдалд тийм их үр нөлөө үзүүлэхгүй ч байж болох юм гээд байгаа юмуу? Хэрвээ тийм бол энэ нь энэхүү товч дүгнэлтэнд орсон ихэнх зүйлүүдтэй зөрчилдөж байна.

Гэлээ гэхдээ өмчийн менежментийн ерөнхий стратегиуд болон тэнцвэртэй бус бэлчээрийн газруудын хоорондын онолын талын зөрөлдөө нь бэлчээрийн газрын нөөцийг хамгаалах талаар нэн даруй хийх үйл ажиллагаанд хориг саад болох ёсгүй. Холчөк нарын хэсэг судлаачид /2000/ үйлдвэрлэлийн удаан хугацааны алдагдал болон бэлчээрийн ашиглалтын өнөөгийн практик үйл ажиллагааны улмаас бий болох бэлчээрийн тахлалттай холбоотойгоор үүсэн тарах орлогын бууралтыг тодорхойлон өгүүлсэн байна.

Үүнийг шийдэх хамгийн энгийн арга бол малын тоог цөөрүүлэх явдал юм. Хамгийн хүндрэлтэй хүчин зүйл нь малын тоог цөөрүүлэхэд хэрэглэх аргыг сонгох асуудал юм. Эхний байдлаар гаргасан зөвлөмжүүдийн жагсаалтыг 11-р сарын 24-нд болсон дугуй ширээний уулзалтын үеэр засгийн газрын удирдах ажилтнуудад танилцуулсан.

Мөн АНУ-аас Монгол улсад суугаа элчин сайдад тэрхүү жагсаалтыг танилцуулсан болно. Эдгээр зөвлөмжүүдийн хамгийн гол зүйл нь малыг бэлчээрлүүлэх зөвлөмж заавруудыг боловсруулах, тэгээд малын тоо ба бэлчээрийн даацын хоорондын тэнцвэртэй байдлыг гаргаж тогтоох хүртлээ түүнийгээ хянан ажиглаж, сайжруулахад гэдэгт оршиж байна. Энэ нь зах зээлтэйгээ сайн ойртохоос эхлүүлээд, тээврийн үйлчилгээг сайжруулах, бүсийн усан хангамжийг дээшлүүлэх, онцгой нөхцөл байдлын үеийн малын тэжээлийн хангамж гэх мэт олон арван онцгой үе шатууд, алхмуудыг багтаана. Эдгээр зөвлөмжүүдийг энэхүү тайлангийн үндсэн хэсэгт тодорхой тайлбарлан танилцуулсан болно.

Зөвлөмжүүд нь одоогийн малын тоо толгойг цөөрүүлэх, бүс нутгийн мал тооллого явуулах, бэлчээрийн газрын нөөцөөс хадлан авах болон түүнийг хамгаалахад системтэйгээр хандахад

дөхөм дэмжлэг болох нөөцийн менежментийн нэгдсэн төлөвлөгөөний бэлтгэл эдгээрийг багтааж байна. Одоогийн тогтож хэрэглэгдэж байгаа арга нь /сүргийн хэмжээг нэмэгдүүлэн одоогийн бэлчээр ашиглалтыг эрчимтэйгээр үргэлжлүүлэх/ бэлчээрийн даацын үр өгөөжтэй байдлыг бууруулж, ингэснээрээ бүс нутгийн болон улсын хэмжээнд өгөх эдийн засгийн бололцоот үр ашгийг багасгаж, бэлчээрийн нөөцөд мэдээжийн байдлаар муугаар нөлөөлөх юм. Цөлийн бүсийн бэлчээрийн систем болон малын тоо толгойд хийсэн саяхны судалгаа /Холечек 2000/ нь бэлчээрийг тогтмол хэтрүүлэн ашигласны улмаас ургамлын үржилд удаан хугацааны алдагдал гарахад хүрдэг гэдгийг илрүүлсэн. Энэхүү удаан хугацааны алдагдал нь тодорхой хэмжээний санхүүгийн алдагдалтай тэнцэхээр байдаг байна. Монголын бэлчээрийн даац нь 1994 оны малын тоо хэмжээг зөвхөн 10 хувиар нэмэгдүүлэх л хэмжээнд тооцоологдож байна хэмээн Шийхи /Баруун ба Одгаард, 1996/ тэмдэглэсэн байна. Нямын /1999/ гаргаж өгсөн малын тоо хэмжээний өсөлтийн талаархи тооцооноос харахад Монголын мал өсөлт Шийхигийн гаргаж ирсэн тооцооноос давах юм шиг байна. Үнэхээр Өмнөговь аймгийн малын тоо өнөөдөр Шийхигийн энэхүү өгүүлээ бичиж байх үеийнхтэй харьцуулбал 200 хувиар өссөн байна. Шиихи /Бруун ба Одгаард, 1996/ цааш нь "Малый тоо толгойг гаднаас шаардлагатай чухал нөөц авахгүйгээр нэмэгдүүлэх аливаа оролдлого нь үр ашиггүй байдалд хүргэдэг" хэмээн өгүүлжээ.

Бид энэхүү төслийн дугуй ширээний танилцуулгад нөөцийн менежментийн зохицуулагдсан төлөвлөгөөг санал болгосон. Япон ба Германы төлөөлөгчид зохицуулагдсан төлөвлөгөөний агуулга болон бэлчээрийн менежментийн үзүүлэн таниулах төслийг хэрэгжүүлэхийг дэмжсэн билээ. Зохицуулагдсан төлөвлөгөөнд хичнээн оролцогч талууд байгаа эсэхээс үл хамааран ойрын хугацаанд ямар нэгэн үйл ажиллагааг хийх шаардлагатай болоод байна. Төсөл, төлөвлөгөөний тухайд олон орныг хамруулсан олон улсын дэмжлэг авах нь оновчтой байх. Гэвч цаг хугацааны асуудал чухал бөгөөд засаж нөхөж болшгүй хохирол учрахаас өмнө ямар нэгэн зүйл хийх хэрэгтэй байна.

Удиртгал

Энэхүү тайлан нь Land & Lakes Inc., -ээс гаргасан Товч мэдээлэл/заавар номон дахь ерөнхий чиг удирдамжийн дагуу, өгсөн зөвлөмжүүдэд хэрэгжүүлэхэд нэмэр тус болох материалуудын хэсэг нь болох байдлаар бэлтгэгдсэн болно. Зөвлөгөө өгөх ажил болон газар дээрх судалгаа 1999 оны 11-р сард хийгдсэн. Судалгааны өмнөх уулзалтыг хээрийн судалгаанд гарахаасаа өмнө Улаанбаатар хотноо нөөцийн асуудал хариуцсан агентлагийн мэргэжилтнүүдтэй хамтарч хийсэн болно.

Судалгааны хэсэгт АНУ-ын Монтана мужийн Миссоула дахь Байгалийн Судалгааны Хэсгийн Байгаль орчны мэргэжилтэн Григори Кеннет, Говийн Санаачийлгын Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан ажилтан Базаррагчаагийн Алтанцэцэг, орчуулагч болон, жолооч нар орж ажиллалаа.

Байгалийн бэлчээр гэдгийг Холечек /1989/ "амьтад амьдралын хэрэгцээний дагуу бэлчээрт тарах, идэш тэжээлээ олж авах бололцоотой хагалж боловсруулаагүй газрыг хэлнэ" хэмээн тодорхойлсон байна. Байгалийн бэлчээр нь ерөнхийдөө байгалийн өвсөн бүрхүүлт бүхий л газрууд болон говь цөлүүдийг багтаадаг байна. Сайжруулсан бэлчээрийн газар нь байгалийн бэлчээрээс шинээр /ихэнхдээ уугуул нутгийн бус малын тэжээлийн ургамлын төрөл зүйлүүд/ болон нэмж агрономын аргаар тордолт тухайлбал, бордолт, усалгаа хийгдсэнээрээ ялгардаг. Монголын хувьд байгалийн бэлчээр ба сайжруулсан бэлчээр гэдгийг ижил утгатайгаар хэрэглэгддэг.

Байгалийн бэлчээрийн газрууд их чухал, ялангуяа Монголын нөхцөлд энэ нь нүүдлийн бэлчээрийн аж ахуй эрхлэгчдийн хувьд хүнс, тос шатахуун болж ерөнхийдөө эдийн засгийн ашиг их байдаг. Хөдөө аж ахуйн салбар нь үндэсний нийт бүтээгдхүүнд голлох байр суурийг

эзэлдэг бөгөөд /Үндэсний Статистикийн Газар, 1997/ эдийн засгийг үйлдвэрлэлийн 34-37 хувийг эзэлдэг байна. Бусад төрлийн орлого бага байдаг говийн бүсийн аймгуудын хувьд хөдөө аж ахуйн бүтээгдхүүн, ялангуяа мал аж ахуйн салбарын бүтээгдхүүнээс орох орлого хамгийн чухал болж байдаг байна.

Монголын нүүдлийн бэлчээрийн аж ахуй эрхлэгчид олон зууны туршид аж ахуйгаа амжилттай эрхэлж, бэлчээрийг зөв зүйтэй ашиглах техникийг хэрэглэж хөгжүүлж ирсэн. Энэхүү техникийн хамгийн гол нь аливаа бэлчээрийг өвс ургамал нь дахин нөхөн ургах хүртэл ашиглахгүй байх, бэлчээрээ тодорхой цаг улирал, хугацаанд байнга сэлгэн солих гэдэг дээр үндэслэдэг байна. Захиргаадгалтын үеийн эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээр мал сүргийн тоо нэмэгдсэн. Малый тоо хэмжээ дээд хэмжээнд хүртлээ нэмэгдсэн /1993-аас 1998 онд Өмнөговь аймгийн хэмжээгээр ямааны тоо толгой хоёр дахин нэмэгдсэн байна/. Чөлөөт зах зээлийн системд бий болсон өрсөлдөөн нь эцэстээ малчдыг цөөн тооны үнэт бэлчээрийн төлөө хүч үзэн тэмцэлдэхэд хүргэх болно. Ийм нөхцөл байдал магадгүй хаяанд ч ирчихсэн байж бол ох юм. Иймэрхүү өрсөлдөөн өвлийн бэлчээр дээр гарч байгаа зөрчилдөөнөөс хэдийнээ харагдаж эхэлсэн. Бэлчээр гэдэг бидний ярилцлага авсан ихэнх малчид, захиргааны албан тушаалтнуудын итгэж бодож явдгаас шал эсрэг бөгөөд энэ нь шавхагдашгүй нөөц ерөөс биш юм. Хоёр долоо хоногийн туршид хээрийн судалгааны аргаар ажиглалт хийгдсэн бэлчээрийн газруудын ихэнх нь даац хэтрүүлэн ашиглагдсан, тахлагдсан байдалтай байлаа. Ургамлын зүйл ангид орсон өөрчлөлтийн талаар нутгийн малчид болон мэргэжилтнүүд ярьж байлаа. Бэлчээрлэлттэй холбоотойгоор ургамлын зүйл ангид орсон өөрчлөлтүүд нь менежментийн нэгжүүдийн хооронд харагдаж байсан ба "хашааны шугамаар эрс тэс ялгаа" байдал ажиглагдаж байсан. Говийн бүсийн бэлчээрлэлтийн хуваарилалт муугүй нэг хэвийн байсан бөгөөд маш цөөн тооны хашаа олдсон. Гэвч Даланзадгад дахь нисэх буудал хашаатай байсан бөгөөд /фото зураг 1- ийг үзнэ үү/ энэ нь хашааны шугамаар ялгарах эрс тэс ялгааг харуулж байв. Тахлалтын байдал нь ялангуяа мал усалдаг худгийн эргэн тойронд ихээр ажиглагдаж байв /фото зураг 2-ыг үзнэ үү/. Тахлалтын байдал нь зөвхөн нэг жилийн ганжилтаас болсон бүс харин нэлээд нягтарсан байнгын бололтой харагдаж байсан. Монголын бэлчээрийн нөөцийг хэтрүүлэн ашигласан талаар бусад хэд хэдэн мэргэжилтнүүд мэдээлж тэмдэглэж ирсэн билээ. Удаан хугацааны тахлалт нь бэлчээрийн газрын үр шимийг муудуулж, улмаар нутгийн мал аж ахуй эрхлэх бэлчээрийн даацыг бууруулан багасгана.

2. Ажлын цар хүрээ

Энэхүү төслийн ажлын цар хүрээ нь орон нутагт газар дээр нь очиж хийх судалгаан дээр төвлөрч байсан. Цаг хугацааны ихэнхийг Монголд өнгөрөөсөн. Төсөл нь "Дундговь, Өмнөговь аймгийн газар нутгийн малын даацын талаар мэдээлэл зөвлөмж өгөх" зорилготой байлаа. Төслийн хүрээнд орон нутгийн малчид, мэргэжилтнүүд болон захиргааны ажилтнуудыг хамруулсан дөрвөн удаагийн семинарыг зохион байгууллаа. Эдгээр семинаруудын гол зорилго нь бэлчээрийн менежментийн үндсэн зарчмуудын талаар ярилцах, өнөөгийн тулгамдсан асуудлууд, бэрхшээл хүндрэлүүд, тэдгээрийг засаж залруулах талаар тавих зорилтуудыг тодорхойлоход оршиж байлаа.

Судалгааны ажлын цар хүрээнд анхандаа дараахи таван үндсэн бүтээл, материалуудыг гаргахаар тодорхойлж байлаа. Үүнд:

- Бүс нутгийн бэлчээрийн менежментийн тайлан
- Усны хамгамжийн талаархи зөвлөмж
- Малчдад зориулсан сургалтын болон техникийн туслалцаа
- Сургалтын материалууд
- Төслийн тайлан

Орон нутагт гурван долоо хоног хийх судалгаагаар дээрх бүх зүйлүүдийг хийж гүйцэтгэнэ гэдэг бол дэндүү ахадсан хэрэг байлаа. Ийм учраас хийж гүйцэтгэх ажлууд дотроос бус нутгийн бэлчээрийн менежмент ба сургалтын материал бэлтгэх гэдэг асуудлууд эн тэргүүнд тавих асуудал хэмээн GREGI-ийн ажилтан тодорхойлсноор эдгээрт гол ач холбогдлоо өгч ажиллалаа.

3. Газар дээрх судалгааны ажил

Төслийн Монголд хийх ажлууд нь Улаанбаатар хотноо засгийн газар болон байгаль хамгаалах бүлгийнхэнтэй хийсэн товч танилцуулга, Дундговь, Өмнөговь аймгуудад 13 хоног явуулсан хээрийн судалгааны ажлаас бүрдэж байлаа. Говьд ажилласан хугацаанд нь тэндхийн байгалийн бэлчээрийг дахин хянан үзэх, малчид мэргэжилтнүүдтэй семинар зохион байгуулах гэсэн хоёр үндсэн үйл ажиллагааг явуулсан.

3.1. Байгалийн бэлчээрийг дахин хянан үзсэн байдал

Машинаар олон арван километр газарт явж бэлчээрийн нөөцөд ажиглалт хийхийн зэрэгцээ туршилтын малчны өвөлжөө, сонгож авсан газруудын өвс ургамлыг шинжлэн судалж, тэдгээр нь хэр ашигтай байрлалтай байгаа зэргийг ажиглан судалж явлаа. Бэлчээрийн байдлыг дүгнэхдээ тэндхийн өвс ургамлын нягтшил, тэсвэртэй байдал, бүтэц, ашиглагдсан хэмжээ болон тарчиг ургамалтай хэсгүүдийг чанарын хувьд үзэж судалж байлаа.

3.1.1. Одоо байгаа малын хэмжээ

Бэлчээрийн нөхцөл байдалд малын тоо хэмжээ нөлөөлж байдаг учраас одоо байгаа малын тоо хэмжээний талаар бүрэн ойлголттой болохын тулд төслийн үйл ажиллагаанд зориулж малын тоог урьдчилсан байдлаар тооцоолж гаргасан. Бэлчээрийн ашиглалт гэдэг бол тухайн газрыг зөвхөн мал адгуус ашиглах гэсэн үйл ажиллагаа байдаг учраас бэлчээрийн байдлыг тодруулах гол үзүүлэлт нь одоо байгаа малын тоо хэмжээг нарийн гаргах явдал байдаг юм. "Бэлчээрт гаргах малын тоохирсон тоо хэмжээг сонгоно гэдэг нь бэлчээрийн менежментийн хамгийн чухал шийдвэр байдаг" хэмээн Холчек /2000/ үздэг. Яг одоогийн байдлыг гаргасан тооцоо судалгаа байхгүй учраас Өмнөговь аймгийн газар нутгийн ургамлын талаархи 1990 оны газрын зургийг бэлчээрийн анхны даацыг тодруулан гаргахад ашиглав. Даацыг үнэлэх, ялангуяа тэнцвэртэй бус бэлчээрийн экологийн системийн даацын талаар их хүчтэй маргаан байдаг. Гэхдээ энэхүү анхны даацын талаархи үнэлгээ, мэдээлэл нь газрын менежерүүдэд цаашид тооцоо судалгаандаа ашиглах зарим өргөн тоон үзүүлэлтүүдийг гаргаж өгдөг.

Малын тоо хэмжээний талаар хамгийн сүүлд /1998/ нийтлэгдсэн материалд үндэслэн тооцоо гаргахад малын тоо өнөөдөр 1.6 сая буюу ХХХ хонины нэгж, өөрөөр хэлбэл бог-той тэнцэнэ гэсэн тооцоо гарч байна. Хонины нэгж гэдэг бол Монголчуудын мал тоолохдоо хэрэглэдэг уламжлалт хэмжүүр юм. Өнгөрсөн жилүүдийн мал өсөлтийн байдал, 1998 оны малын тооллогын дүнг ашиглан тооцоо гаргахад малын тоо өнөөдөр 1,603,804 буюу 2,814,845 хонины нэгжтэй тэнцэнэ гэсэн тоо гарч байна. Дээр нь 1999 онд хил залгаа Дундговь аймагт ган гачиг болсны улмаас Дундговиос Өмнөговьд нэлээд малчид малынхаа хамтаар нүүн шилжин орж ирсэн байна. Ийнхүү байдлаар шилжин орж ирсэн малын тоо доод тал нь 200,000 /Адьяа/, дээд тал нь 1,000,000 /Зандраа/ гэсэн тооцоо гарч байна. Тооцооны хувьд одоогийн байдлаар Өмнөговь аймгийн хэмжээнд нийтдээ 1.6 сая мал, үүн дээр 300,000 мал / мал холилтын үр дүнг 6 сарын хугацаанд пропорционалиар тооцоолон гаргав/ ба 50,000 зээр. байх ёстой гэсэн тооцоог I-р хүснэгтээр үзүүлж байна.

Хүснэгт 3, Өмнөговь аймгийн нийт малын тоо /мянгаар/

	1988	1989	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998
ямаа	391.9	431.6	411.4	428.1	427.3	458.7	551.4	661.5	739.5	869.6	923.7
хонь	282.7	294.7	284.4	296.5	286.8	278.8	309.6	341.1	367.0	404.5	427.2
тэмээ	131.7	133.7	127.9	115.8	102.9	91.2	91.6	92.9	92.9	95.0	97.7
үхэр	23.8	25.3	24.6	25.0	23.9	21.1	24.2	29.4	32.7	37.8	41.6
адуу	65.6	67.8	62.5	62.6	59.9	58.5	77.7	78.6	88.7	101.4	113.6
нийт	995.7	953.1	910.8	928.0	900.8	905.3	1045.0	1204	1321.0	1508.0	1,603.8

Нийт малын тоог уламжлалт хэмжүүр хонины нэгж буюу бод-д шилжүүлэн гаргасан тооцоог хүснэгт 3.2. үзүүлж байна. Бодод шилжүүлсэн ялгааг дараахи байдлаар гаргав.

Хүснэгт 3.2. Өмнөговь аймгийн 1998 малын тоо

Малын төрөл	Тоо	Бод-д харьцах Харьцаа	Хонины нэгжид харьцуулах харьцаа	1998 оны хонины нэгж
ямаа	923,721	0.10	0.9	831,349
хонь	427,175	0.14	1	427,175
тэмээ	97,711	0.67	5.7	556,953
үхэр	41,554	1	6	249,324
адуу	113,643	1	6.6	750,044
нийт	1,603,804			2,814,845

Нэгэнт нийт малын тоог одоогийн байдлаар гаргасан ТОО байхгүй байгаа учраас 1997-1998 оны мал өсөлтийг малын төрөл бүр дээр гаргасан тооцоо ба 1998 оны малын тооллогын дүнг ашиглан, 1999 оны малын тоог урьдчилан тооцоолон бодож гаргалаа. Ингэж тооцоолон гаргасан дүнг 3.3. хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3.3. Өмнөговь аймгийн нийт малын тоог урьдчилан гаргасан тооцоо.

Малын төрөл	Малын тоо 1998 онд	1999 оны малын тоо урьдчилсан байдлаар	1999 оны урьдчилсан тоог хонины нэгжинд шилжүүлбэл	25%-ийн тохиргоо
ямаа	923.7	981.2	883	1,104
хонь	427.2	451.2	451	564
тэмээ	97.7	100.5	573	716
үхэр	41.6	45.8	275	344
адуу	113.6	127.3	832	1,040
нийт	1,603.8	1,705.7	3,014	3,768

Малын тоо хэмжээг тодорхой мэдээлсэн тайлан байхгүй учраас одоо байгаа малын тоог тооцоолон гаргасан тооцоо 25%-иар нэмэгдэнэ гэж үзэж тохиргоо хийлээ. Монголын нэр нь үл мэдэгдэх нэгэн эх сурвалжаас үзэхэд малын тоо хэмжээг гаргасан албан ёсны тоо баримт нь бодит тоо хэмжээнээс ямагт доогуур байдаг гэсэн байсан. Малын тоо толгойг ингэж болит байдлаас доогуур гаргаж мэдээлэх нь гайхмаар ч юмуу, эсвэл Монгол онцлог гэсэн зүйл ерөөсөө биш. Гэлээ гэхдээ мал амьтны хэрэглээний талаархи бодит дүр зургийг гаргахад нарийн тооцоо гаргасан байх нь маш их ач холбогдолтой байдаг. 3.3. хүснэгтийн сүүлийн баганад бичигдсэн тооцоо бол 1999 оны малын тоог хонины нэгжид шилжүүлсэн тооцоонд 25 хувийн тохиргоог хийж харуулсан болно. 1999 оны малын тоо эцсийн тооцоогоор 3,768,000 хонины нэгж гэж гарч байна.

3.1.2. Даац

Даацыг тогтоох нь Нөөцийн Менежментийн Нэгдсэн Төлөвлөгөөний нэг хэсэг болох ёстой. Даацыг гаргахын тулд тохирсон үнэлгээ, тооцоог хийх ёстой. Ийм тооцоо нь өвс ургамлын төрөл зүйлийн, гадаргын налуугийн дундаж, уснаас хэр хол байгаа зай, механик саад тотгор, адгуус амьтадын хэрэглээ, урьд нь бэлчээр ашиглаж байсан түүх, болон бусад өвөрмөц нөөцийн талаархи тэмдэглэлүүдээс бүрдэнэ. Даац гэдэг нь ургамал, өвс ногоо холбогдох нөөцөд байнгын юмуу урт хугацааны гарз хохирол учруулахгүй хэмжээнд амьтан малыг өсгөх дээд хязгаарын хэмжээг хэлнэ хэмээн АНУ-ын Байгалийн Нөөц Хамгаалах Үйлчилгээ /1997/-нээс тодорхойлсон байдаг. Энэхүү хэмжээ нь тухайн газарт малын тэжээлд хэрэглэгддэг ургамалд тарах өөрчлөлтөөс шалтгаалан жилээс жилд өөр өөр байж болно.

Өмнөговь аймагт даацын талаар энгийн тооцоо хийгдсэн. Энэхүү тооцооны зорилго нь судалгааны ажиглалтыг баталгаажуулахын тулд тооцоолон бодох аргаар гаргасан одоогийн малын тоо болон одоо байгаа малын тоог хооронд нь харьцуулсан анализыг хийх явдал байлаа.

Хонины нэгжүүдийн даац нь $C=A(P*U)/F$ бөгөөд үүнд А гэдэг нь газрын хэмжээг гектараар /га/ илэрхийлсэн илэрхийлэл, Р гэдэг нь малд идэгдэх өвсний толгойн хэмжээг килограмаар гаргасан, U гэдэг нь тухайн газрын өвс ургамлыг ашиглаж болох хэмжээ, F гэдэг нь малый тэжээлийн хэрэгцээ /хонины нэг нэгж 547.5 кг өвсийг жилд хэрэглэнэ/ тус тус болно. Өмнөговь аймаг нийтдээ 16.5 сая га газартай, түүнээс 12.2 сая га нь бэлчээр, даац хэтрүүлсэн буюу тахлагдсан бэлчээр ойролцоогоор 950,000 га байна /Золжаргал, 1999/. Гэхдээ тооцооныхоо зорилгод нийцүүлэх үүднээс даац хэтрүүлсэн буюу тахлагдсан 950,000 га бэлчээрийг Золжаргалын /1999/ гаргаж өгсөн нийт 16.5 сая газар ба 12.2 сая бэлчээр гэсэн хоёр тооны ялгаанд багтааж ойлгоно. Бэлчээрийн газраас тарах малый тэжээлийн гарц дунджаар га бүрээс 200 килограмм байхаар тооцоолож байна. Ингээд нийт бэлчээрээс тарах малый тэжээлийн гарц 2,440,000,000 килограмм гэсэн тооцоо гарч байна. Энэхүү малый тэжээлийн гарцын нийт хэмжээ нь тус бэлчээрийн ашиглалтын хэмжээ болон хэрэглэгдэх ёстой. "Цөлийн бэлчээрүүдэд зарим ганшилттай жилүүдийн малжилтын байдлыг оролцуулан малын тэжээлийн дундаж гарцын ойролцоогоор 30-35 хувь нь нөөцөд орчихдог хэмээн судлаачид үздэг" хэмээн Холечек /2000/ тэмдэглэж байна. Тэгэхлээр бидний хувьд малын тэжээлийн 35 хувь нь хэрэглэгдсэн гэж үзэхэд 65 хувь л ашиглагдах болж байна. Дээр дурьдсан $C=A(P*U)/F$ томъёонд орлуулбал $C=12,200,000(200*35)/547=1,561,242$ хонины нэгж гэсэн тооцоо гарч байна.

Одоо байгаа малый тоо толгойг хонины нэгжид шилжүүлэхэд гарсан тоо 3,768,000-ыг дээр бодож гаргасан 1,561,242-д харьцуулахад маш том зөрөө гарч байгаа бөгөөд энэ нь бэлчээрийн ашиглалт хэтэрсэн буюу бэлчээрийг хэтэрхий тахалжээ гэдгийг илтээр харуулж байна.

3.2. Семинар

Семинаруудыг Хулд, Луус, Мандалговь, Даланзадгад гэсэн 4 суманд зохион байуулсан.

Семинар бүрийн ерөнхий чиглэл, зохион байгуулсан хэлбэр өөр хоорондоо ижил байсан. Бэлчээрийн газар болон бэлчээрийн менежментийн шинжлэх ухааны талаархи танилцуулгыг хийсэн. Азийн нүүдлийн бэлчээрийн шинж чанарын онцлог нь тэдгээр нь хамгийн нарийн боловсронгуй байдагт оршдог тухай мөн дурдагдсан /Холечек, 1994/. Америк, Канадад гарч байсан бэлчээрийн талын алдаа, доголдлууд тухайлбал, хогийн сав, хогийн ургамал, Америкийн баруун хэсгийн бэлчээрийн тахлалт, 1885-1886 оны өвөл их хэмжээний мал үрэгдэж асар их хохирол учирсан зэрэг жишээнүүдийг дурдаж тайлбарлан ярьсан.

Семинарын эхэнд хийгдсэн энэхүү удиртгал танилцуулгын эцэст уг семинарт оролцогсдоос энэхүү семинараас хүлээх зүйлүүдийн товч санааг гаргаж өгсөн. Эдгээр семинарууд нь түүнд оролцогсдод уг семинарууд зөвхөн нэг талын мэдээлэл хүлээн авах байдлаар зохион байгуулагдаагүй юм гэдгийг ойлгуулж харилцан ярилцах уур амьсгалыг бий болгосон."Аливаа бэлчээрийн газартай холбогдолтой төслийн төлөвлөгөөг хийх, хэрэгжүүлэхэд түүнд хамаарагдан оролцогч бүх талууд тодорхой эрх хэмжээ эдэлдэг байх ёстой гэдгийг ойлгуулах үүднээс иймэрхүү хамтын ажиллагааг явуулсан.

Өвс ургамал дахин нөхөн үрждэг байх ёстой гэсэн зарчим ойлгогдохгүй байж болох юм. Макро экологийн харилцаа ихээхэн үнэ цэнэтэй мэт харагдавч нхаарлын төвд илүү байгаа ургамлын физиологи нь бараг л тодорхой бус байна. Семинарын үеэр бэлчээрийг хэтрүүлэн хэрэглэсэнтэй холбоотойгоор ургамлын үндэсний систем болон өвс ургамлын жил тутмын гарцад тарах өөрчлөлтүүдийг зургаар үзүүлж байлаа.

Малчид болон захиргааны ажилтнууд аль аль нь 30 жилийн өмнөхтэй харьцуулахад өвс ургамал чанарын болон тооны хувьд ялгаатай, өөрчлөгдсөн гэдгийг хүлээн зөвшөөрч байсан. Өвс ургамалд гарсан өөрчлөлт ялгаануудыг судалгаа шинжилгээний үүднээс бус хувь хүний ажиглалтын үүднээс тайлбарлан тодорхойлж байв. Луус сумаас семинарт оролцож байсан хүмүүс 30 жилийн өмнөхтэй харьцуулахад өвс ургамлын өндөр бараг хоёр дахин багассан бөгөөд өвсний шим ч ийм хэмжээнд хүртэл буурсан гэж тодорхойлж байв. Өвсний өндөр тэмээний гэдэс хүрдэг байсан хэмээн нэгэн малчин ярьж байлаа. Хулд сумаас ирсэн хүмүүс нэгэн малчин өндөр өвсөн дунд уургаа алдчихаад олж чадахгүй байсан тухай үүх түүх ч ярьж байлаа.

Хулд болон Мандалговь сумдад болсон семинаруудын үеэр яригдаж байсан асуудлууд дотор /яригдсан асуудлуудын жагсаалтыг үзнэ үү/ үлийн оготно /хортон мэрэгч амьтан/ ихэссэн тухай яригдаж байсан. Хортон шавьжийн тоо нэмэгдэнэ гэдэг нь мал сүрэг бэлчээрийг их тахалж өвс ургамлыг муутгасныг харуулдаг гэж Шиихи /Баруун ба Одгаард, 1996/ бичжээ.

Малчдын хувьд зах зээлээ дагадаг эдийн засаг гэдгийг нэг л сайн ойлгоогүй байна. Бусдын бэлчээрт зөвшөөрөлгүйгээр дураар нэвтрэхийг хүлээн зөвшөөрч, тэвчдэг Монгол уламжлалт зан заншлыг солих шаардлагатай юм шиг байгаа юм. Малчид мал сүргийн тоо толгойг өсгөх, хажуу зэргэлдээ хөрш байгаа малчдын хэрэгцээг тооцон бодож үзэхгүйгээр бэлчээрийн газраа тэлэх сонирхлоо илэрхийлж байлаа. Үүнээс үүдэн хоорондын маргаан тарах нь зайшгүй юм шиг байгаа юм. Хотоос хөдөө тийш хандсан шилжилтийн дунд малчин өрхийн тоо нэмэгдсэн ба гэхдээ энэхүү өсөлтийг дагаад малын тоо нэмэгдээгүй учир нь тэдгээр шинэ малчин айл өрхүүд гаднаас мал оруулж ирэх замаар бүс нутгийн малчид мал сүргээсээ таслан түгээх замаар тэднийг малжуулдаг байна гэж Фернандез-Жименез /1999/ тэмдэглэжээ. Ийм байдлаар малын тоо өсөх нь мал сүргийн түгээлтийг ч мөн нэмэгдүүлж, ингэснээрээ бэлчээр ч бүрэн буюу хэтрүүлэн ашиглагдахад нөлөөлөх болсон. Малын тоо өсөхөөр бэлчээрийн тахлалт хурдасдаг. Малчид, захиргааны хүмүүсийн аль аль нь хучин чадал, даацын талаар ойлгохгүй, хүлээн зөвшөөрөхгүй байсан. Захиргааны ажилтнууд болон малчдад бэлчээрийг дүүртэл малжуулчихвал яах вэ гэсэн асуултыг тавихад тэд бэлчээр дүүртэл малжина гэж байхгүй хэмээн хариулж байлаа. Миний хувьд тавьсан энэхүү асуулт маань орчуулагчийн ойлголт, орчуулгаар дамжин тэдгээр хүмүүст хэр зөв хүрсэн эсэхэд эргэлзэнгээ дараагийн асуултаа тэдэнд тавьсан билээ. Малыг өсгөхөд тооны хувьд ямар нэгэн хязгаар байдаг гэж боддог уу гэсэн хоёр дахь асуултанд маань мөн л ямар нэг хэлбэрийн хязгаар байх боломжгүй, ёсгүй гэсэн хариултыг өгч байв.

Семинар болгон нэг ерөнхий чиглэл, хэлбэр зохион байгуулалтаар явагдсан. Энэ нь бэлчээрийн менежментийн үндсэн зарчмууд, АНУ-д бэлчээрийн менежментээр олсон амжилт, алдаа онооны талаар ярилцсан ярилцлага болно.

Малчид болон засгийн газрын ажилтнуудад бэлчээрийн менежментийн систем ба Монгол гэдгийг хооронд нь ойлгомтой байдлаар холбож ойлгуулахын тулд малыг бэлчээрлэлтийн систем, Нүүдлийн бэлчээрлэлтийн систем гэдгийг тайлбарлан танилцууллаа. Холечек /1998/ Бэлчээрийн Менежментийн Түүх гэдэг бүлгийнхээ эхэнд "Азийн бэлчээрийн нүүдэлчид нь Америкийн Нэгдсэн Улсад өнөөдөр хэрэглэгдэж байгаа бэлчээрлэлтийн нарийн боловсронгуй системийг хэрэглэж байсан" хэмээн дурдсан байсан.

Семинарт оролцогчдоос бэлчээрийн менежментийн хувьд орон нутгийн болон бүсийн хэмжээнд тулгараад байгаа асуудлуудын жагсаалтыг гаргахыг хүссэн. Нийт зохион байгуулагдсан 4 семинарын үеэр яригдсан гол гол асуудлуудыг доор жагсаасан бөгөөд энэхүү жагсаалтын талаар семинар бүр дээр дахин шүүн тунгаан ярилцсан болно.

- өвс ургамлын гарц, үржил шим
- усны хангамж
- бэлчээрийн амралт
- боловсрол
- ургамлын төрөл зүйлүүдийн бүтэц
- ургамлын төрөл зүйлүүдийн амт шимт
- тариалалт, газар хагалалт
- мал сүргийн чанар
- малын төрлийн зохицуулалт
- хөрсний эвдрэл /зам ба бэлчээрлэлт/
- мэдээллийг урьдчилан мэдээлэх
- малын эрүүл мэнд
- байгаль, ан амьтан /үлийн оготныг оруулна/
- хортон шавьжийн хяналт
- засгийн газрын нөлөө
- байгалийн гай гамшиг

Ийнхүү асуудлуудаа жагсаасны дараа тэдгээрийн тарах болсон шалтгаан болон үр дагавруудын талаар семинарын хэлбэрээр ярилцсан болно. Тухайлбал, өвс ургамлын үр шимийн өөрчлөлт нь дэлхийн цаг агаарын дулааралттай холбогдож тайлбарлагдаж байсан. Мал бэлчээрлэлтээс өвс ургамлын гарц, үржил шимд үзүүлэх нөлөөг давхар тооцоолж үзэж байхыг төслийн зөвлөх, Говийн Санаачилгын ажилтан нарын зүгээс санал болгон, зөвлөж байв. Бэлчээрийг хэтрүүлэн ашигласны улмаас өвс ургамлын гарц, үржил шим урт хугацаагаар буурч ирсэн талаар хийсэн судалгаануудыг дахин дүгнэн үзэж, ийнхүү өөрчлөлтөд орсон ургамлууд, тэдгээрийн үндэсний системийг харуулсан зургуудыг семинарын үеэр оролцогчдын дундуур дамжуулан үзүүлж байлаа.

Нэгэнт асуудлууд тодорхой болсон учраас цаашид тавих зорилтуудын жагсаалтыг хийсэн. Энэхүү дасгалын зорилго нь семинаруудын үеэр хөндөгдөн яригдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд ямар арга хэмжээ авч болох талаар нийт оролцогчдын зүгээс санаа тавьж, энэ тал дээр тэдний сэтгэн бодохыг дэмжих явдал байлаа. Нийт 4 семинарын үеэр дэвшүүлэгдэн хэлэлцэгдсэн зорилтуудыг жагсаалтыг нэгтгэсэн байдлаар доор үзүүлэв.

- боловсролыг дээшлүүлэх
- усны хангамжийг сайжруулах
- сайн ажилладаг худагнуудыг бий болгох
- механикжуулалтыг сайжруулах
- малыг тоог нэмэгдүүлэх

4.0. Бүсийн бэлчээрийн менежмент

Говийн өвс ургамалтай газрын хувьд бүсийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөө их чухал юм. Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний талаархи дараахи санаа, агуулгууд нь ургамал өвс ногоо бүхий тодорхой газар нутагт мал сүргийг ийм байдлаар хуваарилан бэлчээрлүүлэх ёстой гэсэн хатуу хуваарилалт байна гэсэн хэрэг биш юм. Сайн төлөвлөгөө нь бэлчээрийн холбогдолтой бүхий л нөөцийг багтаасан бөгөөд аливаа гай гамшгийн үед өөрчлөгдөн зохицож чадахуйц уян байдлаар хийгдсэн байдаг.

Тайлангийн төлөвлөгөө гэсэн энэхүү хэсэг нь судалгааны ажлын дагуу Газар Ашнглалт, Бэлчээрийн Менежментийн Зөвлөх Григори Кеннетийн хийх ажлын хүрээнд бэлтгэгдэн хийгдлээ. Говийн Санаачлага Төсөл хоёр чиглэлийн асуудалд илүү ач холбогдол өгч ажиллаа. Нэгдүгээрт, Дундговь, Өмнөговь аймагт семинарууд зохион байгуулах; хоёрдугаарт, бүсийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөө бэлтгэх. Энэхүү төлөвлөгөөний агуулга, санаанууд нь концепцийн байдлаар хийгдсэн бөгөөд зөвлөмжийн хэсэгт тусгагдсан Нөөцийн Менежментийн Нэгдсэн Төлөвлөгөөний үндэс суурь, хүрээг бий болгож байгаа болно. Зөвлөхөөр ажилласан нийт хугацаанд цаг хугацаа хамгийн ихээр зарцуулсан ажил бол газар дээр хийсэн судалгааны үеэр малчид, захиргааны ажилтнууд, газрын мэргэжилтнүүдтэй тулгамдсан асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх талаар ярилцсан ярилцлагууд байлаа. Бэлчээрлэлтийн менежментийн бүрэн төлөвлөгөөнд ашиглачихаар мэдээлэл маш бага, тэр бүү хэл байгаа хэдэн мэдээлэл нь нэлээд хуучирсан, сүүлийн үеийн тоо баримтаар шинэчлэгдэх шаардлагатай болчихсон байсан.

Хоёр чухал зорилгыг тавьсан байсан: Говийн бүсийн бэлчээрийн тахлалтыг багасгах; бэлчээрийн холбогдолтой бүхий л нөөцийг - байгаль, ан амьтны орчин, хөрс, экологийн үйл ажиллагаа /цөлжилтийг багасгах/ - сайжруулах, тэдгээрийг хэвээр нь хадгалах, хамгаалах. Түүний хажуугаар бэлчээр, бэлчээрийн нөөцийн хувьд ашиг өгөхүйц байгаль орчны болон эдийн засгийн холбогдолтой сайн шийдвэр гаргахад нь туслах зорилгоор малчид болон захиргааны хүмүүст бэлчээрийн менежментийн талаар мэдээлэл өгөх зорилтыг мөн тавьж байлаа. Дараахи төлөвлөгөөний товч санаа, агуулга нь АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Газрын төлөвлөгөөний материалыг сайжруулан, Монголд хэрэглэж болохуйц байдлаар зохих өөрчлөлтийг хийсэн хувилбар юм. Энэ нь төлөвлөгөө хийхэд эхлэл нь болох бөгөөд Монголын шинжлэх ухааны олон салбарыг хамарсан баг үүнийг улам боловсронгуй болгож сайжруулан цаашдаа үргэлжлүүлэх ёстой. Энэхүү гол агуулга санаа нь засгийн газар болон бэлчээрийн мэргэжилтнүүдэд төлөвлөгөө хийх үйл явцын чухам хаана нь яваа талаар зохих санаа оноо өгч, нөөц бололцооныхоо алийг нь эн тэргүүнд тавих гэдэг дээр шийдвэр гаргахад тус дөхөм болох болно.

4.1. Урьдчилсан төлөвлөгөө

Урьдчилсан төлөвлөгөө гэдэг бол төлөвлөгөө хийх үйл явцын үр ашиг, эрчимд хамгийн чухал нөлөөтэй хэсэг байдаг. Аливаа нутаг дэвсгэрт зориулсан урьдчилсан төлөвлөгөө хийхэд дараахи үйл ажиллагаа багтдаг. Үүнд:

- Бэлчээр хамгаалалтын төлөвлөгөө хийхэд хэрэгтэй дараахи мэдээлэл, материалуудыг цуглуулах:
 - Газрын зураг /агаарын болон байр зүйн/.
 - Хөрсний талаархи мэдээлэл /газрын зураг ба тайлбар/.
 - Байгалийн бэлчээрийн экологийн талын тайлбар, сайжруулсан бэлчээр болон хаддан авах газрын тодорхойлолт.
 - Байгаль, ан амьтны орчныг үнэлэх ёс журам, шат дамжлага.
 - Тоног төхөөрөмж, хэрэгсэл жишээлбэл, тайрч огтлох хэрэгсэл, хүрз, хутга.
 - Малчдад үндсэн зарчим, техникийн талаар тайлбарлан, үзүүлэн таниулахад хэрэглэгдэх мэдээллийн материал.
 - Бэлчээрийн газар ашиглалтын хэрэглээний программ ажиллах боломжтой систем бүхий компьютер.

- Төлөвлөөг хийх ажилд өөрийгөө бэлтгэх:
 - Сайжруулсан бэлчээр, хадлангийн зориулалттай газрын экологийн үндсэн зарчим болон өөрийн ажиллаж байгаа газар нутгийн бэлчээрийн өвөрмөц шинж байдлын талаар мэдлэгтэй байх; эдгээрийн талаар малчидтай харилцан ойлгомжтойгоор ярилцаж санал бодлоо солилцох бэлтгэлтэй байх.
 - Байгалийн бэлчээрийн чиг хандлага, байгалийн болон сайжруулсан бэлчээрийн байдал, малый тэжээл, малый тооллогыг үзүүлсэн газрын зургийг ойлгож, тайлбарлах чадвартай байх; бэлчээрийн менежментийн төлөвлөгөө болон бэлчээр хамгаалалтын төлөвлөгөөний тайлбар тодорхойлолтыг бэлтгэх.
 - Өөрийн ажиллаж байгаа газар нутагт хэрэглэгдэж болох бэлчээрийн газрын хамгаалалтын бүхий л практик үйл ажиллагааг ойлгох.
 - Тухайн газар нутгийн мал аж ахуйн үйл ажиллагааг ойлгосон байх.
 - Бэлчээр хамгаалалтын төлөвлөгөөний есөн үе шатыг ойлгож, сайн мэддэг байх.
- Малчдыг аль болох сайн ойлгосон байх. Энэ нь малчдын чухам юу хүсээд байгаа, тэдний цаашдын тавьж байгаа зорилтууд, түүнчлэн бэлчээрийн газрын экологийн зарчмын талаар малчид хэр мэдлэгтэй байгаа зэргийг мэдэж авахад их дөхөм болдог. Энэхүү олж авсан мэдээллээ одоо байгаа бэлчээрийн хамгаалалтын төлөвлөгөөний тэмдэглэл болон хувь малчидтай ямар нэгэн байдлаар ганцаарчилж ажиллаж байсан юмуу ажилладаг тийм мэргэжилтэнтэй уулзах зэрэг байдлаар баталгаажуулах.
- Малчидтай хатуу болзоо тогтоож, төлөвлөгөөний цаг хугацааны талаар ярилцах. Тэдэнд төлөвлөгөөний цаг хугацаа, түүнийг товлох, баримтлах гэдэг ямар их ач холбогдолтой болохыг ойлгуулах. Тухайн өдрийн тохирсон цагт ирж ажлаа гүйцэтгэх.
- Байгалийн бэлчээр, сайжруулсан бэлчээр, хадлангийн газар, бэлчээрт болон хадланд ашигласан тариалангийн газрыг хамгаалах талаар малчдыг ерөнхий ойлголт мэдлэгтэй болгох. Хамгийн чухал мэдэж ойлгож байх зүйлүүд гэвэл:
 - Өөрийн газар нутгийн ургамлыг ялгаж тодорхойлдог,
 - Өвс ургамал яаж ургадаг,
 - Ургамлын гэсвэр гэвчээр,
 - Бэлчээрийн ашиглалтын төрөл, хугацаа, хэмжээ болон гал түймэр, бэлчээрийн ургамлын бүлэгт менежментийн талаар гаргах шийдвэр зэргээс үзүүлэх нөлөө,
 - Нутгийн ургамал, сайжруулсан бэлчээрийн өвс ургамал, хадлангийн зориулалттай ургамлын зүйл ангиуд өөр хоорондоо хэрхэн өрсөлддөг,
 - Экологийн талын ойлголт /хөрс, ургамлын хоорондын шүтэлгээг харьцааг тайлбарлах,
 - Бэлчээрийн цаашдын хандлага,
 - Бэлчээрийн байдал,
 - Малый тэжээлийн хэмжээ,
 - Бэлчээрийн газрын хувьд тохиолдож болох бэлчээрийн өөр өөр нөхцлүүд болон ургамлын зүйл ангиудаас тарах малын тэжээлийн гарц, орчны үнэлгээ,
 - Бэлчээрийн газрын олон талт ашиглалт,
 - Хөрсний эвдрэл, нөхцөл, бохирдол,
 - Бэлчээрийн газрын хог хаягдлын менежмент,
 - Усны чанар, гарцыг хамгаалах, сайжруулахад бэлчээрийн газрыг мал аж ахуйтай нь хослуулан хэрхэн арга эвийг нь олох,
 - Өвс ургамал усыг ашиглах зарчмууд, бэлчээрийн менежментийн үүнд үзүүлэх нөлөө,
 - Бэлчээрийн менежмент нь агаарын чанарыг тухайлбал, үнэр, салхинд туугдсан тоос шорооноос хамгаалах, сайжруулах,
 - Тэжээмэл амьдын хоол, ус, байрны хэрэгцээ,
 - Ан амьтдын хоол, ус, орогнох газрын хэрэгцээ,

Малчдын хувьд эдгээр үндсэн зарчмуудыг ойлгосон байх нь бэлчээрийн газрын төлөвлөлтийн үйл явцад их чухал ач холбогдолтой байдаг. Ийм мэдлэггүйгээр тэд өөрсдийн нөөцийг үргэлжлүүлэн илрүүлж, анализ хийх, тулгарч буй бэрхшээл хүндрэлүүд, тэдгээрийн үүсэн тарах болсон шалтгаануудыг тогтоох, улмаар цаашдын зорилгоо тодорхойлох, хүндрэлтэй асуудлуудыг шийдэх арга замаа шийдэн сонгох, цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөг хийх, хэрэгжүүлэх, үр дүнг дүгнэх, зохих өөрчлөлт сайжруулалтыг хийж чадахгүйд хүрдэг.

Бэлчээрийг хамгаалах төлөвлөгөөг амжилттай хийж хэрэгжүүлэх нь малчдын өдөр тутмын амьдрал туршлагадаа тулгуурлан найдвартай, үндэслэл бүхий экологийн болон эдийн хувьд хэрэгжихүйц шийдвэр гаргах чадвараас бүрэн хамаардаг байна. Малчдын газар нутагтай холбоотой байдаг учраас дээрх ойлголтуудыг малчдад өгөх талаар Монголын шинжлэх ухааны олон салбарыг хамарсан баг /МНТ/ эрчимтэй ажиллах ёстой.

4.2. Байгалийн бэлчээр, байгалийн сайжруулсан бэлчээр, сайжруулсан бэлчээрийн газар, хадлангийн газар, бэлчээрт болон хадланд ашигласан тариалангийн газрыг хамгаалах төлөвлөгөөний есөн үе шат

Төлөвлөгөө хийх үйл ажиллагааны нэгдүгээр хэсэгт эхний дөрөв буюу тулгарч байгаа хүндрэлтэй асуудлуудаа тодруулах, цаашдын зорилгоо тодорхойлох, нөөцөө бүрдүүлэх, нөөцийн мэдээлэлд дүгнэлт хийх гэсэн үе шатууд ордог. Эдгээр үе шатууд нь өөр хоорондоо харилцан холбоотойгоор үйлчилж, заавал тодорхой ээлж дараалал шаардахгүйгээр голдуу нэгэн цаг хугацаанд явагддаг байна. Малчид ерөнхийдөө өөрсдийн тодорхойлсон асуудлуудад МНТ-ийн зүгээс туслалцаа үзүүлэхийг хүсдэг. Хэрвээ малчид тэдгээр асуудлуудтай холбоотой экологийн ерөнхий зарчмуудыг ойлгохгүй бол аливаа шинж тэмдгийг тодорхой асуудал хэмээн ойлгож, эдгээр шинж тэмдэг тарах болсон шалтгааныг мэдэхгүйд хүрч магадгүй юм. Үнэндээ шалтгаан гэдэг бол эмчилгээ шаардсан жинхэнэ хүндрэл бэрхшээл, асуудал болж байдаг. Энэ утгаараа, хэдийгээр үе шатууд нь нэгэн зэрэг явагдах, өөр ээлж дараалалд орох, төлөвлөлтийн үйл явцад дахин давтагдах хэдий ч бэлчээрийн газрыг хамгаалах төлөвлөгөөг хийхдээ дагах логик дараалал гэж байдаг.

Бэлчээрийн газрын экологийн үндсэн зарчмуудыг заах юмуу ойлгуулсны дараа /урьдчилсан төлөвлөгөөний нэг хэсэг болгон/ төлөвлөлтийн үйл явцын эхний үе нь нөөцөө тодруулж бүрдүүлэх явдал юм. Үүний дараа нөөцийн талаархи мэдээлэлд дүгнэлт хийж, хүндрэлтэй асуудлуудаа тодруулж, тэгээд зорилгоо тодорхойлдог.

Дараагийн хэсэгт Үндэсний Төлөвлөлтийн Горим Журмын Гарын авлагад заасан дарааллаар төлөвлөлтийн үе шатуудыг үзүүлэх болно.

4.3. Тулгамдсан асуудлуудыг тодорхойлох

4.3.1. ерөнхий байдал

МНТ-д хандаж техникийн туслалцаа хүсэж байгаа малчид тэдэнд тулгараад байгаа тулгамдсан асуудлуудаа хараад ойлгогчихсон түүнийгээ шийдвэрлэх хүсэлтэй байдаг. Гэтэл тэдний ойлгож мэдэрсэн тэрхүү асуудлууд нь үнэн хэрэгтээ жинхэнэ хүндрэлтэй асуудлуудын улмаас илэрч гарч ирдэг шинж тэмдгийн чанартай зүйлүүд байж магадгүй байдаг. Жишээлбэл, нэг малчин хөрсний элэгдэл, малын тэжээлийн гарц багасаж байгааг мэдэрчээ. Тэр малчны хувьд эдгээр нь түүнд тулгараад байгаа жинхэнэ хүндрэлтэй асуудал болох нь тодорхой. Гэтэл энэ нь үнэндээ бэлчээрийг тасралтгүй байнга ашигласан болон бэлчээрийн дутуу дулимаг, муу хуваарилалтын дунд илэрч гардаг шинж тэмдгүүд байдаг байна. Энэ тулгамдсан асуудал нь өвсөн бүрхүүлт газрын ургамал, өвс ногооны тэсвэртэй байх чадварыг бууруулж, улмаар үхэж үрэгдэхэд хүргэдэг байна. Ийм байдлаар өвс ногоо дахин сайжирч нөхөн үйлдвэрлэлтэнд орж чадахгүй, муу чанарын ургамлаар солигдож эхэлдэг байна. Ингээд ургамал, өвс ногооны бүрхүүл болон дотоод бүтцэд гарсан өөрчлөлт

нь элэгдлийг бий болгож, малыг тэжээлийн гарц, чанарыг муудуулж, ан амьтдын хоол хүнс, хоргодох байрыг багасгадаг байна. Асуудлын гол нь малчид тулгамдсан асуудал гэдгийг анхандаа юу гэж ойлгож байсанд бус харин бэлчээрийн зөв зүйтэй менежмент дутагдсаны улмаас дээрх шинж тэмдгүүдийг илэрч гарсанд байгаа юм.

МНТ-ийн зорилго бол малчдыг зөвхөн аливаа хүндрэл бэрхшээлийн шинж тэмдгийг мэдэрч ойлгох бус харин тулгараад байгаа жинхэнэ асуудлыг ялган салгаж ойлгоход туслах явдал юм. Бэлчээрийн менежмент муу байгаа нь тулгараад байгаа гол асуудал болж байгаа тохиолдолд МНТ-ийн бэлчээр амгаалагчид малчдад бэлчээрийн менежмент муу байна гээд хэлээд байх биш харин малчдад бэлчээрийн менежмент муу байгаад асуудлын гол оршиж байна гэдгийг ойлгуулахад удирдан чиглүүлж

ажиллах ёстой. Үүний тулд малчдад бэлчээрийн газрын экологийн систем гэдгийг ойлгоход урьдчилсан төлөвлөгөөнд заасанчлан туслалцаа үзүүлэх байдлаар ажиллаж болно. Тулгараад байгаа жинхэнэ асуудлыг ойлгож мэдэх үйл явц нь нөөцийг илрүүлэн судлах, нөөцийн талаар цугларсан мэдээлэлд дүгнэлт хийх үе шатуудаар дамжин урьдчилсан төлөвлөгөө хийх байдлаар үргэлжилнэ.

4.3.2. Тулгараад байгаа хүндрэлтэй асуудлуудыг ойлгож таних тогтсон жишиг /стандарт/

Малчдыг бэлчээрийн газрын экологийн систем болон нөөцөд тооллого хийх үйл явцаар дамжин тулгараад байгаа хүндрэлтэй асуудлуудын шинж тэмдэг, шалтгаануудыг танин мэдэж, ойлгоход чиглүүлэн удирдана.

4.3.3. Үйл ажиллагаанууд

Тулгамдсан асуудлуудыг тодруулахад дараахи үйл ажиллагаануудыг гүйцэтгэнэ.

Хийх зүйл	Ямар байдлаар гүйцэтгэх
Малчид тулгараад байгаа хүндрэлтэй асуудлуудаа өөрсдийн ойлгосноор тодруулах	Хувь хүмүүсийн ажиглалт. Иймэрхүү ажиглалтууд нь ихэнхдээ тухайн асуудлыг үүсгэсэн шалтгааныг тодруулахыг шаардана гэсэн ойлголтгүйгээр хийгддэг.
Малчид бэлчээрийн газрын экологийн системийн талаархи ойлголтоо сайжруулна	МНТ ажилтнууд бэлчээрийн газрын экологийн системийг малчдад ойлгуулах үүднээс тэдэнд хичээл зааж, газар нутаг дээр тайлбарлан үзүүлнэ.
Малчид өөрсдөдөө тулгараад байгаа жинхэнэ хүндрэлтэй асуудлууд, тэдгээрийн шалтгаануудыг ойлгож мэдэрнэ.	МНТ нь малчдад дараахи үйл ажиллагаанд туслалцаа үзүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> ▪ Бэлчээрийн газрын экоогийн системийн нөөцөд тооллого хийх, ▪ Хөрс, агаар, ургамал, амьтанд тулгараад байгаа бүхий л хүндрэлтэй асуудлуудын шинж тэмдгүүдийг тодруулах, цаашид үүсэн тарах бэрхшээлүүд болон тэдгээрийн нэг бүрийн шалтгааныг тодруулах, ▪ Төлөвлөгөөний үйл явцад нөөцийн талаархи тулгамдсан асуудлууд яригддаг учраас эдгээр тулгамдсан асуудлуудын үед илрэх шинж тэмдгүүдийн шалтгаануудыг ойлгох.

4.4. Зорилгоо тодорхойлох

4.4.1. ерөнхий байдал

Нийт малчид өөрсдийн иж бүрэн зорилттой байдаг. Энэхүү зорилтууд нь малчдын хүссэн зорилгоо амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай бэлчээрийн газрын экологийн системийн тохирох менежментийг хамруулсан ч эсвэл хамруулаагүй байж бол ох юм. Хамруулаагүй тохиолдолд үүний гол шалтгаан нь экологийн систем дотор явагддаг хоорондын бүхий л харилцан үйлчилгээнүүдийг ойлгоогүйгээс үүдэн гардаг байна.

Төлөвлөгөөний үйл явцад малчдад туслалцаа үзүүлэхэд малчид бэлчээрийн газрынхаа экологийн системээ бүрэн ойлгосон, түүнийхээ нөөцөд тооллого хийж, тэгээд тулгараад байгаа асуудлуудаа тодруулсны дараа зорилгоо өөрсдөө тогтоосон байх ёстой. Малчидтай ажиллаж байх хугацаандаа эдгээр гурван үйл явц бүрэн дуустал тэдний урдаа тавьж байгаа эцсийн тодорхой зорилгуудын талаар байн байн асуухгүй байвал зүгээр байдаг. Зарим хүмүүс зорилго нэг л илэрхийлсэн бол тэр талаархи бодол шийдвэрээ солих дургүй байдаг. Малчдыг зорилгоо гаргаж илэрхийлэхээс нь өмнө тэдэнд бэлчээрийн газрынхаа нөөцийг ойлгож, тооллого хийх, тулгараад байгаа бэрхшээлтэй асуудлуудаа тодруулахад нь туслалцаа үзүүлэх хэрэгтэй.

4.4.2. Нийтийн жишиг /стандарт/

Малчид экологийн болон эдийн засгийн хувьд ашигтай, зөв зүйтэй зорилтыг дэвшүүлэн гаргахад МПТ-ийн ажилтнууд удирдан чиглүүлнэ.

4.4.3. Үйл ажиллагаанууд

Зорилт тодруулахад дараахи үйл ажиллагаануудыг явуулах шаардлагатай.

Хийх зүйл	Ямар байдлаар гүйцэтгэх
Малчид менежментийн зорилгоо илэрхийлнэ	Энэ нь бэлчээрийн газрын экологийн зарчим, нөөцийн байдал, тулгараад байгаа асуудлуудын талаар бүрэн ойлголтгүйгээр хэд хэдэн удаа хийгддэг.
Малчид экологи, эдийн засаг, нийгмийн хувьд ашигтай, зөв зүйтэй менежментийн зорилтуудыг илэрхийлдэг.	МПТ-ийн ажилтнууд нь: <ul style="list-style-type: none">▪ Малчид бэлчээрийн газрын экологийн системийг ойлгосныг баталгаажуулах,▪ Малчдад өөрсдийн газар нутгийн бэлчээрийн газрын нөөцийн тооллого хийхэд туслах,▪ Малчдад нөөцийн хувьд тулгараад байгаа бэрхшээлтэй асуудлууд, тэдгээрийн шалтгаануудыг ойлгож, мэдрэхэд туслах,▪ Малчид экологи, эдийн засаг, нийгмийн хувьд үр ашигтай, зөв зүйтэй зорилтуудыг тогтооход туслах

4.5. Нөөцийн тооллого

4.5.1. Ерөнхий байдал

Өөрсдийн газар нутгийн экологийн зарчмыг нэгэнт ойлгочихсон малчид "Миний бэлчээрийн цаашдын хандлага ямар байх бол?" "Бэлчээрийн маань байдал ямар байгаа бол?"

"Миний бэлчээрийн болон түүний нөөцийн хоорондын харьцаа яаж явагдаж байгаа бол?"

гэсэн асуултуудыг ерөнхийдөө тавьдаг. Энэ үеэс л малчин бэлчээрийнхээ газрын экологийн систем хувирч өөрчлөгддөг, өөрийн бэлчээрийн газрыг аль болох боломжоороо мэдэж

ойлгосон байх нь хичнээн чухал байдаг зэргийг ойлгож ухаарч эхэлдэг байна. Ингээд малчдад бэлчээрийн газрын нөөцийг тоолоход та бүхнээс туслалцаа шаардах хүсэл аяндаа төрдөг байна.

4.5.2. Нийтийн жишиг /стандарт/

МПТ-ийн ажилтнууд нь малчдад бэлчээрийн газрынхаа экологийн системд тооллого хийх, одоогийн байдлаар хэрэгжүүлж байгаа бэлчээрийн менежментийн бодлого төлөвлөгөө, мал аж ахуйн практик үйл ажиллагаа, мал сүргийн үзүүлэлт зэрэг экологи болон гүйцэтгэлийн өнөөдрийн байдлын талаар бүрэн мэдлэгтэй болоход нь тусална. Энэ үйл явцын үеэр бэлчээр хамгаалагчид нь бэлчээр хамгаалалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд малчдад бэлэн байгаа нөөц бололцооны талаархи ойлголтыг сайжруулж хөгжүүлэх хэрэгтэй.

4.5.3. Үйл ажиллагаанууд

Нөөцийн тооллого явуулахад хийх шаардлагатай үйл ажиллагаануудыг доор үзүүлэв.

Хийх зүйл	Ямар байдлаар гүйцэтгэх
Тооллогод хэрэгтэй материалуудыг баталгаа, найдвартай болгох.	МПТ нь газрын зургууд /агаарын фото зурагнууд болон хөрсний газрын зурагнууд/, талбайд хэрэглэх багаж хэрэгсэл, бэлчээрийн экологийн байрлалын тайлбар зэрэг техникийн талын мэдээллийг баталгаа, найдвартай болгох.
Тооллогыг явуулах.	<p>МПТ-ийн ажилтнууд нь:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Хөрсний тайлбар, газрын бодит байдлыг гаргасан агаарын фото зурагнууд дээр малчны бэлчээрийн байрлалыг тодорхойлох, ▪ Бэлчээрийн байдал, цаашдын хандлагыг тодруулж, төлөвлөгөөний газрын зураг дээр тэмдэглэх, ▪ Бэлчээрийн хуваарилалтыг тодруулан газрын зурагт үзүүлж өгөх, ▪ Гол гол бэлчээрийн байрлал болон ургамлын төрлүүдийг тодруулах, ▪ Хашаа, усан хангамжийн тоног төхөөрөмжүүд, давс хужиртай газар, малын хэвтэр газар, зам, хашаа хороо, хортой ургамалтай газар болон бусад чухал өвөрмөц шинж тэмдэгтэй газруудыг газрын зураг дээр тэмдэглэх, ▪ Хөрсний эвдрэл, нөхцөл байдал, бохирдлыг тодруулах, ▪ Хур тунадасыг тодорхойлох, ▪ Усны чанар, гарцад үнэлгээ хийх, ▪ Малын тэжээлийн тооллогыг сайжруулах, ▪ Мал, ан амьтдын тооллогыг сайжруулах, ▪ Малын тэжээл, амьтны хэрэгцээний талаархи тооцооны хуудсыг сайжруулах, ▪ Мал аж ахуйн практик үйл ажиллагаа болон малын үзүүлэлтийг гаргаж тогтоох, ▪ Хэрвээ соёлын нөөц байгаа бол түүнийг тодруулах, ▪ Бэлэн байгаа нөөцийг тодруулах.

4.6. Нөөцийн мэдээлэлд дүгнэлт хийх

4.6.1. Ерөнхий чиглэл

Тооллогын үйл явц дууссаны дараа мэдээлэлд дүгнэлт хийх нь малчны хувьд тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлыг тодруулахад хэрэгтэй тустай байдаг. Дахин хэлэхэд нөөцийн талаархи мэдээлэлдээ дүгнэлт хийхээсээ өмнө малчид бэлчээрийн газрынхаа экологийн систем ба түүний талаархи концепцийг ойлгосон байх явдал маш их чухал шаардлагатай байдаг. Ингэснээр малчид экологийн систем дэх хөрс, ус, агаар, ургамал, амьтны нөөцийн хоорондын харьцаа түүнчлэн малчдад тулгараад байгаа бэрхшээлтэй асуудлуудын шалтгаануудыг ойлгож чадна.

4.6.2. Нийтийн жишиг /стандарт/

МТГ нь тооллогын үр дүнд гарсан мэдээлэлд дүгнэлт хийхэд нь малчинд тусалж ингэснээрээ тэд нөөцийн асуудалд тулгараад байгаа хүндрэл бэрхшээлүүд болон цаашдын шинэ боломжуудын талаар мэдэж авах болно.

4.6.3. Үйл ажиллагаанууд

Нөөцөд дүгнэлт хийхэд шаардагдах үйл ажиллагаануудыг доор үзүүлэв.

Хийх зүйл	Ямар байдлаар гүйцэтгэх
Бэлчээрийн газрын экологийн системийн одоогийн байдлыг тухайн байрлалын нөөц бололцооны бандалтай харьцуулан үнэлгээ өгөх	МТГ нь малчдад дараахи зүйлүүдийг тодруулахад туслалцаа үзүүлнэ. Үүнд: <ul style="list-style-type: none">Одоо байгаа өвс ногоо, ургамлын төрөл зүйлүүд нь малын тэжээлийн гарц, түүний орчин, усны чанар болон хэмжээ, агаарын чанар, хөрс хамгаалалт, амьтдын үзүүлэлтэд шаардагдаххэмжээнд байж чадаж байгаа эсэх,Аливаа хүссэн ургамлын төрөл зүйлийн тэсвэртэй байх байдалБэлчээрийн цаашдын хандлага /байгалийн бэлчээр дээр хийнэ

Тулгарч байгаа бэрхшээлтэй асуудлуудыг тодруулхад дараахи үйл ажиллагаануудыг явуулна.

Хийх зүйл	Ямар байдлаар гүйцэтгэх
Сайжруулалтын алтернатив шийдлүүдийг боловсруулах	Ургамлын менежментийн сонголт хийх, малчдыг дэвшилтүүлэн тавьсан менежментийн зорилгод тохирсон болон нөөцийн бэрхшээлтэй асуудлуудыг тодруулахын тулд бий болгосон чанартай хэмжүүр болохуйц туслах болон хурдасгах практик үйл ажиллагаануудыг сонгох. Малчид өөрсийн хэрэгцээ шаардлагын дагуу өөрт тохирсон алтернативыг сонгож болхуйц олон хувилбар алтернативуудыг боловсруулах.

4.8 Алтернатив шийдлүүдийг үнэлэх

4.8.1 Ерөнхий чиглэл

Алтернатив шийдлүүд боловсруулагдсаны дараа малчин өөрийн тависан зорилго болон түүний хувьд тулгараад байгаа нөөцийн асуудлуудаа шийдвэрлэхэд тохирохуйц тийм алтернативыг тодруулах үүднээс боловсруулсан бүх алтернативуудад үнэлгээ хийнэ.

4.8.2 Нийтийн жишиг /стандарт/

Алтернатив шийдэл бүрийн үр нөлөө тус тусдаа үнэлэгдэх ба эдгээр алтернативууд нь малчидын урдаа тависан зорилт, тэдэнд тулгараад байгаа нөөцийн хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх юмуу багасгах чадварт харицуулалт хийгдэнэ.

4.8.3 Үйл ажиллагаанууд

Алтернатив шийдлүүдийг үнэлэхэд явуулах шаардлагтай үйл ажиллагаануудыг доор үзүүлэв.

Хийх зүйл	Ямар байдлаар гүйцэтгэх
Сайжруулалтын алтернатив шийдлүүдийн экологи, эдийн засаг, нийгмийн үр нөлөөг тодруулах	Тодруулах зүйлүүд: <ul style="list-style-type: none">▪ Хүссэн ургамлын хэсэг бүлгийг бий болгох алтернатив шийдлийн үр нөлөө▪ Хөрс, ус, агаар, ургамал, амьтанын нөөцөд тулгараад байгаа хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх буюу багасгах алтернатив шийдлийн үр нөлөө.▪ Бүх алтернатив шийдлийн эдийн засаг, нийгмийн бололцоо. Бэлчээрийн газрын хэрэглээ гэдэг шийдвэр дэмжих систем нь сайжруулах алтернативийн эдийн засгийн үнэлгээг гаргахад туслалцаа үзүүлнэ.▪ Үйлдвэрлэгч нь практик үйл ажиллагааны системд ач холбогдол өгөн, түүнийг хэрэглэх хүсэл, чадвар, сэтгэл байгаа эсэх.

4.9. Шийдвэр гаргах

4.9.1. Ерөнхий чиглэл

Бүх алтернатив шийдлүүдийг үнэлж дүгнэсний дараа малчин өөрийн зорилгод тохирсон тийм алтернативыг сонгох талаар шийдвэр гаргана. Үүний тулд бүх алтернативуудыг өөр хооронд нь харьцуулж дараахи зүйлүүдийг тодруулна. Үүнд:

- Хүссэн ургамлын хэсэг бүлгийн сайн бий болгох эсэх,
- Хүссэн цаг хугацаанд хийгдэх эсэх,
- Санхүү эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай нь байж чадах эсэх,
- Малчны мэдлэг, чадварт нийцэж тохирсон эсэх,
- Малчны цаг зав, займы хязгаарт таарч тохирсон эсэх.

Алтернатив шийдлээ сонгосны дараа, түүнийг тухайн малчин хэрэглэхэд туслах зорилгоор тохиромжтой хэлбэрт оруулах.

4.9.2. Нийтийн жишиг /стандарт/

МГТ нь малчинг түүний зорилгод хамгийн тохирохуйц алтернатив шийдлийг сонгоход удирдан чиглүүлнэ. Энэ талаар хийсэн шийдвэр нь бэлчээр хамгаалах төлөвлөгөөнд тэмдэглэгдэнэ.

4.9.3. Үйл ажиллагаанууд

Шийдвэр гаргахын тулд дараахи үйл ажиллагаануудыг явуулах шаардлагатай.

Хийх зүйл	Ямар байдлаар гүйцэтгэх
Малчид өөрсдийн зорилгод хамгийн сайн тохирох алтернатив шийдлийг сонгоно. Хэрэглэх хуваарь.	МИТ малчид өөрсдийн зорилгод хамгийн сайн тохирох нэг алтернатив шийдлийг сонгохын тулд бүх алтернатив шийдлүүдийг өөр хооронд нь харьцуулахад нь туслалцаа үзүүлнэ. МИТ-ийн ажилтнууд малчин тухайн сонгосон алтернатив шийдлээ амьдрал хэрэглэх урт хугацааны хуваарийг гаргахад туслалцаа үзүүлнэ. Тэрхүү урт хугацааны хуваарь нь уг алтернативыг хэрэглэж амжилтанд хүрэх болон цаг хугацааны хувьд бүрэн бололцоотой байхаар хийгдэх ёстой.
Бэлчээр хамгаалах төлөвлөгөө бэлтгэх.	МИТ нь бэлчээр хамгаалах төлөвлөгөө хийхэд нь малчинд тусална. Энэхүү төлөвлөгөөнд дараахи зүйлүүд багтсан байна. Үүнд: <ul style="list-style-type: none">○ Бэлчээр хамгаалалтын газрыш төлөвлөгөө. Энэ төлөвлөгөөнд орох зүйлүүд нь:<ul style="list-style-type: none">▪ Тухайн хэсгийн хил хязгаар,▪ Төлөвлөж байгаа бэлчээрийн хэсгийн хил, 1тоо, хэмжээ,▪ Талбай хэсэг бүрийн газар ашиглалт,▪ Чанар, ач холбогдлоо алдаагүй өнөөдрийн болон ирээдүйд төлөвлөсөн практик үйл ажиллагааны байршил,▪ Бэлчээрийн цаашдын хандлага,▪ Сайжруулсан бэлчээр болон хадлангийн хэсгийн ургамал, амьтны төрөл зүйл,▪ Бэлчээрт ашиглагдсан ойн хэсгийн газар болон байгалийн сайжруулсан бэлчээр дэх малын тэжээлийн үнэлгээ,▪ Зам, мал сүрэгтэй холбоотой шаардлагатай үйлчилгээ, тоног төхөөрөмж гэх мэт бусад мэдээлэл▪ Хөрсний газрын зураг, таних тэмдгүүд,▪ Тооллогын бүх мэдээлэл,▪ Малын тэжээлийн тооллого, малын тооллого, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө,▪ Сонгосон сайжруулах алтернатив шийдэл болон түүнийг хэрэглэх хугацааны тэмдэглэл,▪ Баримтын хуудас буюу эсвэл ажлын хуудас,○ МИТ-ийн ажлын хавтаст хэрэгт дараахи зүйлүүд багтсан байна. Үүнд:<ul style="list-style-type: none">▪ Малчинд байгаа бүх мэдээлэл,▪ Газрын хэсгүүдийн байрлалын чиглэл,▪ Малчны хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалт,▪ Техник туслалцааны талаархи тэмдэглэлүүд,▪ Хүрсэн амжилтуудын тэмдэглэлүүд.

4.10. Төлөвлөгөөний хэрэгжилт

4.10.1. Ерөнхий байдал

Малчин одоо ингээд төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхэд бэлэн боллоо. МИТ-ийн боловсон хүчний зүгээс малчинд хэрэгтэй шаардлагатай бүхий л практик, дадлагуудыг хэрэглэхэд нь техник туслалцаа үзүүлэх болно.

Хэрэглэхэд хамгийн хүндрэлтэй, төвөгтэй практик үйл ажиллагаа гэвэл бэлчээрийн менежментийн дадлагууд болох малын тэжээлийн хадлангийн менежмент ба заавар зөвлөгөөний дагуу бэлчээрлүүлэх явдал байдаг. Эдгээр дадлага үйл ажиллагаа нь хадланг зөв зүйтэй, үр ашигтай байдлаар хадаж авах, бэлчээрт гаргаж байгаа мал сүрэг нь тоо, төрлийн хувьд тухайн бэлчээрийн өвс ургамлын бүтцийг цаг хугацаа, төрх байдлын хувьд хүссэн чанар хэмжээнд байлгахуйц байхын зэрэгцээ малый болон анхаарлын төвд байгаа ан амьтдын хэрэгцээг хангахуйц байдалд байлгах гийм хэмжээнд барьж байхыг хэлнэ. Үүнийг амжилттай хийхийн тулд малчдын зүгээс МПТ-ийн боловсон хүчнээс шаардлага хэрэгцээтэй ургамал, өвс ногоонд ажиглалт хийх болон менежментийн стратегидаа тохиргоо хийх зэрэгт суралцахын тулд ойрын бөгөөд байнгын туслалцааг хүсч магадгүй юм.

МПТ бэлчээрийн даацыг тогтооход тусалж болно. Түүнчлэн МПТ нь газар эзэмшигчдэд мал сүргийг бэлчээрт найдвартай бөгөөд ашигтай байдалд бэлчээрлүүлэхийн тулд малын тоо, төрлийг тогтоох шийдвэрээ гаргахад нь туслалцаа үзүүлж болно.

4.10.1.1. Малын тэжээлийн тооллого

Малчид малый тэжээлийн нөөц /нөөцийн хязгаар, шаардлага/ болон мал, амьтдын тэжээл хэрэглэх бэлчээрийн зуршлын талаар тодорхой мэдлэгтэй байх ёстой. Мал сүргийн тоог эхний байдлаар гаргахад малчид өөрсдийн дадлага туршлага дээр аль болох тулгуурлах хэрэгтэй. Орон нутгийн хэмжээнд гаргаж байгаа бүтээгдхүүн болон малын тоо толгойн талаархи мэдээлэл нь малчны туршлага дээр нэмэлт байдлаар хэрэглэгдэж болно.

Малый тэжээлийн тооллого тооцоог хийхдээ үйл ажиллагаа явуулж байгаа хэсгийн менежментэд хамрагдаж байгаа нэгж /бэлчээр юмуу талбай/ бүрд малын тэжээлийн хангамж ямархуу хэмжээнд байгааг харуулж байхаар хийх хэрэгтэй.

4.10.1.2. Малын тооллого

Үйл ажиллагаа явуулж байгаа хэсэгт одоо байгаа болон цаашид байрлуулахаар төлөвлөж байгаа тэжээвэр амьтдын тоог гаргах ёстой. Энэхүү мал тооллогоноос тусдаа хүссэн мал аж ахуйгаа хөтлөхөд шаардлагатай малын тоог бас гаргах хэрэгтэй. Энэ нь ерөнхийдөө малый төрөл, үүлдэр нас гэсэн байдлаар хийгдэнэ. Хэрвээ менежментэнд хамрагдаж байгаа хэсэг тодорхой нэг сүргийн тухайд онцгой байгаа бол түүнийг дурдаж тэмдэглэж өгөх хэрэгтэй. Менежментэд хамрагдаж байгаа хэсэг бүрд тохирсон тооны мал сүргийн бэлчээр идэлт өдрөөр, долоо хоногоор, сараар аль эсвэл улирлаар тарах ба нэптэсэн нийт дүн нь малын тэжээлийн хэрэгцээг тэжээлийн гарцтай уялдаа бүхий төлөвлөгөө хийхэд хэрэглэгдэнэ.

4.10.1.3. Зааврын дагуу бэлчээрлүүлэх хуваарьт нөлөөлөх үйл ажиллагаанууд

Зааврын дагуу бэлчээрлүүлэх төлөвлөгөөнд нөлөөлөх зүйлүүдийг тодруулах ёстой. Үүнд дараахи зүйлүүд орно:

- Мал аж ахуйн дадлага туршлага
- Малд хэрэгтэй шим тэжээлүүд Малын тэжээлийн чанарын шаардлагууд
- Практик үйл ажиллагааг хэрэглэх шаардлагууд
- Ховор ургамал, ан амьтдын хэрэгцээ
- Усны чанарын хэрэгцээ болон хэмжээ
- Махчин амьтдын асуудлууд
- Хорхой шавьжны асуудлууд
- Шимэгч хорхойн асуудлууд
- Хортой ургамлын асуудлууд
- Амьтдын орогнох байрны асуудлууд
- Гоо сайхны таашаалын болон нийгмийн тал дээр анхаарах асуудлууд
- Соёлын нөөцүүд

- Тусгай анхаарал сайжруулалт хэрэгтэй байгаа газрууд.

4.10.1.4. Бэлчээрлэлтийн хуваарь

Малый тэжээлийн ба мал тооллогыг хийгээд зааврын дагуу бэлчээрлүүлэх хуваарийг тодруулахад нөлөөлөх бусад зүйлүүдийг тодруулсны дараа зааврын дагуу бэлчээрлүүлэх хуваарийг боловсруулна. Үүний тулд малчин мал сүргээ бэлчээрт хөдөлгөөнд оруулах хуваарийг гаргана. Энэхүү хуваарь нь бэлчээрийг дараахи нөхцөл байдал, хэмжээнд байлгах байдлаар хийгдэх ёстой. Үүнд:

- Малын тэжээлийн хэрэгцээ ба хангамж хоорондоо тэнцвэртэй байдалд байх,
- Ургамал, өвс ногоо ургах хэрэгцээг хангах,
- Малый идэх тэжээлийн чанарыг хангах,
- Малый эрүүл мэнд, мал аж ахуйн хэрэгцээг хангасан байх,
- Менежмент болон үйл ажиллагаа явуулж байгаа хэсгүүдэд бусад үйл ажиллагааг явуулах шаардлага хэрэгцээг хангах,
- Малчны зорилгыг хангах.

Малын төрөл, үүлдрийн болон анхаарлын төвд байгаа ан амьтдын бэлчээрээс авах ёстой шим тэжээлийн түвшинг хангах үүднээс нэмэгдэл тэжээлийн шаардлага хэрэгцээнүүдийг тогтоох хэрэгтэй. Малд шаардлагатай шим тэжээлийн талаархи зөвлөгөө зааврыг 6-р бүлгээс үзнэ үү.

Зааврын дагуу бэлчээрлүүлэх төлөвлөгөө нь болзошгүй хүндрэл бэрхшээлүүд тухайлбал, ган гачиг мэтийг нарийн тусгасан цогцолбор төлөвлөгөө байх бөгөөд нөөцийн менежмент болон эдийн засгийн боломжийг баталгаатай болгохын тулд бэлчээрлүүлэх зааврыг нөхцөл байдалд зохицуулан тохируулах удирдамжийг багтаадаг. Төлөвлөгөө нь хэрэгжилтийн эхний үе шатуудад тулгарч болзошгүй хүндрэлтэй асуудлуудыг /ган гачиг/ малчин хэрхэн яаж мэдрэх талаар тусгах ба бэлчээрийн нөөц, мал сүрэг, ан амьтан болон эдийн засгийн үйл ажиллагаанд учрах элэгдэл хохирлыг зайлуулах буюу багасгах үйл ажиллагааны төлөвлөгөөг багтаасан байна.

4.10.1.5. Туслах болон хурдасгах практик үйл ажиллагаанууд

Туслалцааны болон хурдасгалтын практик үйл ажиллагаанууд нь техникийн хэлбэр юмуу тусгай хэрэглээний заавруудыг шаардагдана. МИТ-ийн боловсон хүчний зүгээс малчныг мэдээллээр хангах, газар дээр нь үйл ажиллагаа явуулахад шаардлагатай техник туслалцаа үзүүлэх талыг хариуцна.

4.10.2. Нийтийн жишиг /стандарт/

МИТ нь төлөвлөсөн практик үйл ажиллагааг амжилттай хэрэглэхэд нь малчинд техник туслалцаа үзүүлнэ.

4.10.3. Үйл ажиллагаанууд

Төлөвлөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаануудыг доор үзүүлэв.

Хийхзүйл	Ямар байдлаар гүйцэтгэх
Зааврын дагуу бэлчээрлүүлэх төлөвлөгөөний хуваарь.	МИТ-ийн боловсон хүчний зүгээс малчинд зааврын дагуу бэлчээрлүүлэх төлөвлөгөөнүүдийн хэлбэр ба хэрэглээний тал дээр туслалцаа үзүүлнэ. Зааврын дагуу бэлчээрлүүлэх төлөвлөгөөг хэрэглэх нь үргэлжлэх байдлаар явагдах үйл явц юм. Өдөр тутмын тогтсон хэв шинжид нөлөөлж болзошгүй шийдвэрийг өдөр бүр гаргах ийм үйл явц учраас олон малчны хувьд энэ нь амьдралын хэв шинжид нь хийгдэх өөрчлөлт болдог байна. Үйл ажиллагаа явагдаж байгаа хэсгийн хувьд ургамал, мал, ан амьтдад нөлөөлөх менежментийн шийдвэр болгон нь төлөвлөгөөний хэсэг болж явна. Төлөвлөгөөг хэрэглэх гэдэг нь өдөр тутмын үйл явц. МИТ-ийн боловсон хүчнүүд малчдад бэлчээрийн газар, мал сүрэг, ан амьтдын байдалд ажиглалт хийх, амжилтанд хүрэх менежментийн шийдвэрийг гаргахад нь газар дээр нь очиж туслалцаа үзүүлэх хэрэгтэй.
Туслах ба хурдасгах практик үйл ажиллагнуудыг хэрэглэх	Туслах практик үйл ажиллагаа, тухайлбал, худаг ус, хадгалалтын тоног төхөөрөмж, дамжуулах хоолой, шуудуу энэ бүгдийг үр ашигтай байдлаар ашиглаж амжилтанд хүрэхүйц техникийн хэлбэр байдлын дагуу хийж суурилуулна. МИТ-ийн боловсон хүчний зүгээс тэдгээрийн хэлбэр болон суурилуулалтын тал дээр туслалцаа үзүүлнэ. Хурдасгах практик үйл ажиллагаа, жишээлбэл, цэвэрлэгээний менежмент, зэрлэг ургамлын хяналт, шим тэжээлийн талын менежмент, сайжруулсан бэлчээрийн менежмент, шаардлагатай байгаа онцгой газруудыг засаж сайжруулах энэ бүхнийг техникийн хэлбэрийн дагуу цаашид үр өгөөжөө өгөхүйц хэмжээнд хийж гүйцэтгэнэ.

4.11. Үр дүнг үнэлэх

4.11.1. Ерөнхий байдал

Малчид өөрсдийн бэлчээрийн газартаа менежментийн төлөвлөгөөг хэрэглэж эхэлсний дараа, МИТ түүнийг үргэлжлүүлэх тал дээр туслалцаа үзүүлнэ. Дээр хэлсэнчлэн бэлчээрийн менежмент гэдэг бол үргэлжилж байдаг тийм үйл явц юм. Малчинд зааврын дагуу бэлчээрлүүлэх хуваарийг хэрэглэсний дараа түүнийхээ үр дүнд үнэлгээ хийхэд нь МИТ-ийн боловсон хүчний туслалцаа хэрэгтэй болж магадгүй юм. Энэ нь малчны хувьд шинэ зүйлд суралцах үргэлжилсэн сургалт, МИТ-ийн боловсон хүчний хувьд илүү туршлага дадлага хуримтлуулалт болдог. Бэлчээрийн менежмент нь малчин тавьсан зорилгоо илүү сайн амжилттайгаар гүйцэлдүүлэхийн тулд зөв тал руу нь тохируулга хийх байдлаар ихэнхдээ өөрчлөгдөж болдог. Малчид бэлчээрийн менежментийн талаархи мэдлэгээ дээшлүүлж, бэлчээрийн менежментээ илүү эрчимтэй сайн болгож өөрчлөхийг эрмэлзэх болсон тохиолдол олон байдаг. Энэ нь ихэнхдээ усны байдлыг илүү сайжруулах чиглэл дээр төлөвлөгөөгөө эргэж харж сайжруулах, аль эсвэл зааврын дагуу бэлчээрлүүлэх төлөвлөгөөгөө бүхэлд нь дахин засаж сайжруулахыг шаарддаг.

Малчны тавьсан зорилтууд өөрчлөгдөх буюу төхник төхнологийн шинэчлэл малчдад нөлөөлөх явдал элбэг тохиолддог. Малчны техник болон менежментийн талаархи мэдлэг, чадвар нэмэгдэхийн хэрээр нөөцийн холбоотой шинэ асуудлууд илүү мэдрэгдэж ирдэг.

МИТ нь орон нутагт бэлчээрийн менежментийг хэрэглэсэн туршлагаадаас мэдээллийг үргэлж хүлээн авч цуглуулж байдаг. Ийм байдлаар бэлчээрийг сайжруулахад дараах үр дүн, үр

дагаврын талаархи мэдээллийн баазыг бүрдүүлдэг. Үр дүн, үр дагаврын талаар хийсэн үнэлгээ нь цаашид малчдын төлөвлөгөөг хийх үйл явцад хэрэгтэй болдог.

Олон малчдын хувьд төлөвлөгөөний эхний үйл явц нь бэлчээрийн менежментийн талаар ойлгож суралцах зөвхөн эхлэл нь болдог. Зарим малчид үргэлжлүүлэн дагаж хийх үнэлгээгээ МИТ-ийн туршлагатай боловсон хүчний туслалцаагүйгээр хийснээс болоод зохих амжилтанд хүрэхгүй тохиолдол ч гарч болзошгүй. Ийм учраас бэлчээр хамгаалах төлөвлөгөөг амжилттайгаар найдвартайгаар хэрэгжүүлэх, цаашид малчдад туслалцаа үзүүлэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулахын тулд малчин бүртэй байнгын харилцаа холбоотой байх шаардлагатай.

4.11.2. Үйл ажиллагаанууд

Үр дүнг үнэлэхэд хийгдэх үйл ажиллагаануудыг доор үзүүлэв.

Хийх зүйл	Ямар байдлаар гүйцэтгэх
Гарсан үр дүнд үргэлжлүүлэн үнэлгээ хийх, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг сайжруулах, дахин эргэж харах, үүний хариу, үр дүнгийн талаархи мэдээллийг олж авах.	<p>Гарсан үр дүнд үргэлжлүүлэн үнэлгээ хийхийн тулд малчинтай тодорхой цаг тогтох. Тэднийг бэлтгэлтэй байлгахын тулд байнгын харилцаа холбоотой байхын учир шалтгааныг тайлбарлах.</p> <p>Хэрэглэсэн бэлчээрийн менежментийн үр дүнг газар дээр нь дахин хянах. Малчид ургамлын бүлгийн цаашдын хандлагыг хэрхэн мэдэх тал дээр зааж сургаж, туслалцаа үзүүлэх. Өвс ногоо, ургамал хүссэн хэмжээ байдлаар үргаж, мал болон анхаарлын төвд байгаа ан амьтдын тэжээлийн чанар, гарцыг хангаж байхаар, түүнчлэн хөрс, ус, ургамал, амьтны нөөцийн хэрэгцээг хангах тийм байдлаар бэлчээрийн менежментэнд тохиргоо хийхэд малчдад туслах.</p> <p>Практик үйл ажиллагаанд туслах болон түүнийг хурдасгах хэрэглэлийн хуваарийг дахин хянаж үзэх. үргэлжилсэн амжилтыг үнэлж дүгнэхэд ашиглагдаж байгаа хэсгүүдийг дахин хянаж үзэх.</p>

Салхины хүчээр зарим элэгдэл үүсэх нь байгалийн жам ёс байдаг. Гэхдээ газартаа буруу хандсанаас салхинд хөрсөө алдах түвшин хэмжээ ихсэхэд хүрдэг. Дэндүү их мал өсгөх, зарим нэг мэдрэмтгий хөрстэй газрыг хэтрүүлэн ашигласнаас үүдээд тухайн газрын ургамал дэвслэгдэн үхэж, хөрс нягтаршин улмаар шинээр ургах өвс ногоо үндэслэх боломжийг багасгадаг байна.

Бэлчээрийн хэсгийг нийтэд нь үзэж харах

Эрүүл саруул бэлчээрийн газрыг төлөвлөхийн тулд нийт газар нутгийг нэг нэгж байдлаар тооцож үзэх ёстой байдаг. Нэг хэсэг газрын хувьд хийх газрын менежментийн төлөвлөгөө түүний эргэн тойронд байгаа хэсгүүдэд зарим нэг байдлаар ямагт нөлөөлж байдаг.

Хэтрүүлэн ашиглагдсан ба бүрэн хэмжээндээ хүрч ашиглагдахгүй байгаа газруудыг олж тогтоох

Төлөвлөгөөг зөв зүйтэй хийх эхний алхам бол хэтрүүлэн ашиглагдаж байгаа газруудыг тодруулах явдал байдаг. Зохих хэмжээндээ хүрч ашиглагдахгүй байгаа газруудыг олж тогтоох нь малчдын хувьд мал сүргээ дахин хуваарилан бэлчээрлүүлэх, тэдгээр газруудыг байнгын бэлчээрийн хуваарьтаа оруулах боломжуудыг нээж өгдөг.

Сул хөрс нь элэгдэлд амархан өртөх газрыг ашиглахыг болиулах

Зарим газрууд ашиглахад бусдаасаа илүү эмзэг байдаг. Нийт газар нутгийн ерөнхий байдлыг хэвийн байдалд байлгах үүднээс газрын иймэрхүү эмзэг хэсгүүдийг ашиглахгүй байх хэрэгтэй. Ийм газруудыг бэлчээрт ихээр ашиглах тохиолдолд элэгдэл үүсч, газар, мал сүрэг болон малчдад урт хугацааны сөрөг үр дагавар учрах болно.

Малын баас, өтөг бууцыг бөөгнөрүүлэхгүйн тулд малыг тараан бэлчээрлүүлэх ба тэдгээрийн усны нөөцөд нийлүүлэхээс хамгаалах

усны чанар нь түүний ойролцоо малын баас, өтөг бууц ихээр хуримтлагдсанаас болоод муудаж болдог. Цаг хугацааны туршид хөрсөн дээрх бохир зүйлүүд хөрсөнд шингэж улмаар усны нөөцөд хүрдэг байна. Ийм замаар худгийн ус муудах тохиолдолд гарч болдог байна. Чанар муутай ус малын эрүүл мэнд үржүүлгэд муугаар нөлөөлөх болно.

Жилээс жилд мал аж ахуйн үйл ажиллагааг тогтворжуулах

Бэлчээрийн зөв зүйтэй менежмент нь тогтвортой бөгөөд ашигтай үйл ажиллагааг бий болгодог. Буруу, муу менежмент нь нөөцийг хөнөөж, аюултай гарз хохиролд хүргэдэг. Нарийн бэлтгэсэн төлөвлөгөө, бэлчээрийн менежментийн олон талт хувилбаруудыг анхаарч ажиллавал нэлээд гарз хохирлыг гаргахгүй байж болох талтай.

Малын тэжээлийн гарц ба бэлэн байдал

Тохирсон цаг хугацаа, ашиглалтын үргэлжлэх байдлаас шалтгаалан авах хадлангийн хэмжээ ихсэж болдог.

Менежментийн зорилгод хүрэх

Менежментийн зорилгодоо хүрэхийн тулд малчин хаана ямар өөрчлөлт хийгдэх ёстой гэдгийг тодруулахын тулд бэлчээрийн үйл ажиллагаануудыг сайтар хянан ажиглаж байх хэрэгтэй. Ийм үйл ажиллагаанууд нь дараахи байдлаар илэрнэ. Үүнд:

- Малын тоо гаргах
- Хуваарь хийх
- Тараан байрлуулах
- Бэлчээрийн эрч хүч
- Мониторинг

Малын тоо

Малын тоог зөв тохирсон хэмжээнд сонгох гэдэг бол малчны бэлчээрийн менежментийн хувьд хийх хамгийн гол шийдвэр юм. Ургамал, өвс ногоог тогтмол байдлаар хүссэн хэмжээнд байлгахуйц тоо хэмжээтэй малыг бэлчээрт гаргана гэдэг бол богино ба урт хугацааны туршид эдийн засгийн өндөр өгөөжөө эргүүлэн өгдөг байна. Зөв тохирсон малын тоог бэлчээрийн газрын хэмжээ, өвс ногооны тэсвэртэй байдал, газрын налуу байдал болон усны хүрэлцээ байдлыг тооцоолж гаргана.

Дэлхий даяар янз бүрийн тоо хэмжээний /бага, дунд, их/ малын бэлчээрт үзүүлэх нөлөөний талаар судалгаанууд хийгдсэн байдаг. Тэдгээр судалгаанууд нь бэлчээрт малыг бага ба дунд тоо хэмжээнд байлгахад олон тооны өгөх үр өгөөж, ашигтай байдаг гэдгийг харуулсан байдаг. Хэрвээ ургамал, өвс ногоо бага хэмжээгээр идэгдэх юм бол илүү их хэмжээний амт шимтэй байдлаар цаашдаа ургадаг байна /5.1. үзүүлэлтийг үзнэ үү/. ургамлын үндэс болон навчны хэсгийн байдлыг хэвийн байдалд байлгах нь тухайн ургамлын амьд байдлаар тэсвэрлэн үлдэхэд гол хүчин зүйл нь болж өгдөг байна. Хүссэн ургамал, өвс ногоог зүй

бусаар хэтрүүлэн их хэмжээгээр бэлчээрт ашиглаж эхэлбэл тэдгээр өвс ургамлын үржил шимтэй байдал, тоо хэмжээ аяндаа буурч эхэлдэг /5.2. үзүүлэлтийг үзнэ үү/. Энэ нь сүүлдээ шим тэжээлийн хувьд бага өвсөн бүрхүүлт газрыг буй болгож мал, амьтдыг өөрсдийн хоол тэжээлийг олохын тулд өөр тийшээ шилжихэд хүргэдэг байна. Малын тоо толгойг хэмжээ хэтрүүлснээс үүдээд олон арван бэрхшээл хүндрэлтэй асуудлууд гардаг байна.

Өвс ургамлын бүлэг хэвийн хэмжээнд байх, бэлчээрийн цаашдын байдал баталгаатай болсон тийм бэлчээрт багаас дунд хэмжээний тооны малыг бэлчээрлүүлэх хэрэгтэй. Үүний дүнд үржүүлгийн хувьд өндөр амжилтанд хүрч малын жин ч өсдөг байна. Дунд ба бага тооны малыг бэлчээрт гаргаснаар мал бүрээс өгөх эдийн засгийн ашиг их хэмжээгээр нэмэгдэх болно. Усгүй хуурай газарт бэлчээрлүүлэх малын зөв тохирсон тоо хэмжээг гаргахад малын тэжээлийн нөөцийн 25-40 хувийг ашигласан гэж тооцоолж гаргана.

Зөв тохирсон малын тоо хэмжээ нь бэлчээрийн байдал, хуваарьтай нарийн холбоотой байдаг. Эдгээр элементүүдийн хоорондын тэнцвэртэй байдал бэлчээрийн системийг бий болгодог. Бэлчээрийн нийт систем нь ургамал, өвс ногооны байдалд нөлөөлөх боловч малын тоог зөв зүйтэйгээр тогтоогоогүй тохиолдолд бэлчээрийн байдал, хуваарьт зохицуулалт хийсэн тохируулга нь олигтой үр нөлөө үзүүлэхгүй. Бэлчээрийн системийн мониторинг маш анхааралтайгаар хийснээр бэлчээрийн даацыг 10-30 хувиар жирийн хэмжээнд бэлчээрт үргэлжлүүлэн ашиглахаар нэмэгдүүлж болдог байна. Гэлээ гэхдээ малын тоо толгойг хэтрүүлснээс үүссэн бэлчээрийн элэгдлийг ямар ч шилдэг бэлчээрийн систем арилгаж чаддаггүй байна.

Хуваарь хийх

Бэлчээрт гаргах цаг хугацаа гэдэг бол бэлчээрийн газарт маш ихээр нөлөө үзүүлдэг. Бэлчээрийн газруудыг ургасан ургамлын төрөл, онцлог шинж тэмдгүүдээс хамаараад аль болох олон хэсгүүдэд хувааж үзэх хэрэгтэй. Малчин ингэж хуваасан хэсгүүд хэрхэн өөрчлөгдөж байгаад нарийн анхаарлаа хандуулж, тэдгээрийг нөөцийн болон хэрэгцээний байдлыг үнэлэх үндсэн дээр хуваарьт оруулах хэрэгтэй. Хуваарь гаргахдаа дараахи зүйлүүдийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Хортой ургамал: Зарим газруудад хортой ургамлууд улирлын шинж чанартайгаар ихээр гарч ирдэг.
- Усны хүрэлцээтэй байдал: Хуурай улирал шувтрах үеэр зарим худагнууд ширгэдэг. Малый тэжээл бүрэн гүйцэд ургаж эхлэхэд ус үргэлж бэлэн хүрэлцээтэй байдаг уу?
- Амьдын шилжилт, хөдлөлтийг хялбар болгох: усны хүрэлцээ, халуун, эвдрэлд орсон газар, бэлчээрт хүрэх зай зэрэг нь зарим нэг газрыг ашиглахад тохиромжгүй байж болох юм.
- Бэлчээрийн хэсгийн тоо: Бэлчээрийн хэдэн хэсэг байх вэ? Эдгээр хэсгүүд нь хэр удаан байх вэ?
- Бэлчээрийн хэсгийн хэмжээ: Бэлчээрийн хэсгийн хэмжээ нь бэлчээрлүүлэх хугацаанд нөлөөлнө.
- Ургамлын амьдралын мөчлөг ба хэрэгцээнүүд: Ургамал, өвс ногоонд ургаж төлжиж, цэцэглэх эсвэл амрах хугацаа хэрэгтэй. Зарим ургамлууд намрын сүүл сард дараагийн жил шаардагдах нүүрстөрөгчөө хуримтлуулаад маш зав чөлөөгүй байдаг.
- Малд хэрэгтэй шим тэжээлүүд: Намар орой хүртэл ургасан ургамал малд хэрэгтэй шим тэжээлээр бага болсон байдаг.
- Үржүүлгэ ба төллөлт: Зарим газар нутаг нь үржүүлгэ төллөлтөд илүү тохиромжтой байж болох юм.
- Улирлын шинжтэй хөрсний чийгшилтийн нөхцөл /хөрсний нягтралт/: Газрыг хөрсний чийгшилт ихээр явагдаж байгаа үед хэрэглэснээр хөрсний нягтрал ихсэж улмаар өвс ногоо дахин ургахад хүндрэлийг бий болгодог.

- Өөр өөр улирал, өвс ногооны өсөлтийн үе шатуудад ургамлын эмзэг байдал: Зарим өвс ургамлуудын хувьд аливаа нөлөөлөлд онцгой өртөх тийм үеүд байдаг. Энэ нь ихэнхдээ өвс ургамал ургаж эхлэх эхний үе шатууд болон намар орой цагаар идэвхгүй байдалд орох тэр үеүд байдаг байна.
- Газар нь хэр зэрэг бэлчээрлэлтийг тэсвэрлэх: Энэ нь мониторингийн хөтөлбөрийн дагуу гол гол газрууд болон ургамлын төрөл зүйлүүдийг нарийн ажигласнаар гарч ирнэ.
- Бэлчээрийн бэлэн байдал: Аливаа газар нутгийг бэлчээрт ашиглагдахаасаа өмнө өвс ногоо нь ургаж хөрс шороо нь сайжирсан байх бодолцоог олгох хэрэгтэй. Бэлчээрийн бэлэн байдал гэдэг нь үржлийн мөчлөгийн тодорхой цэг бөгөөд энэ нь тухайн газар нутгийн өвс ногоо, хөрсөнд байнгын эвдрэл гэмтэл учруулахгүйгээр бэлчээрлэлт эхэлж болох тийм үеийг хэлдэг байна. Зохимж таарамжгүй цагт бэлчээрийг ашиглаж эхэлвэл салхины хүчинд үүсэх хөрсний элэгдэл ихсэх, хөрсний нягтрал үүсэх болон хөрсөнд бусад өөрчлөлтүүд бий болж ургамал, өвс ногоо ургах цаашдын үйл явцад муугаар нөлөөлнө.
- Бэлчээрлэлтийн эрч байдал: Дараагийн бүлгээс үзнэ үү.
- Үрийн гарц, үр дахин сүүлгалт: Өвс ногоо, ургамлыг шинээр тарьж ургуулахад чанар сайтай үр гаргаж аваад, түүнийгээ зөв зүйтэй цацаж тараах шаардлагатай байдаг. Үүнийг нь доор үзүүлсэн бэлчээрлэлтийн системийн өнжилттэй эргэлтэнд хийж гүйцэтгэж болно.
- Амралт: Сайжруулсан бэлчээр, газар нутгийг 3-4 жилд нэг удаа өвс ногооны бүтэн улирлын туршид амрааж бэлчээрт ашиглахгүй байх явдал их ач холбогдолтой байдаг.

Бэлчээрлэлтийн өнжилттэй эргэлт гэдэг нь ерөнхийдөө малын тэжээлийн гарцыг хэвийн байлгах юмуу сайжруулахад ашиглагдахаар зориулагдсан олон төрлийн бэлчээр, төрөл бүрийн мал сүргийн системээс бүрддэг. Сүргийн нягтшил дунд зэрэг, бэлчээрт гаргах цаг хугацаа нь тогтсон цаг хугацааг бодвол урт байна. Энэхүү системээр малын гурван сүрэг бэлчээрийн дөрвөн хэсэгт ээлжлэн, бэлчээрийн нэг хэсгийг байнга өнжөөх байдлаар бэлчинэ. Малый тоо нь бэлчээрийн дөрвөн хэсэгт бэлэн байгаа малын тэжээлд тэнцвэртэй байхаар тоо хэмжээнд байна. Бэлчээрийн хэсэг бүрийн өнжих хугацаа ойролцоогоор дөрвөн сар байна. Ийм замаар бэлчээрийн нэг хэсэг жил бүрийн тодорхой хугацаанд бэлчээрт ашиглагдахгүй байх болно. Ийм төрлийн систем дөрвөн жил тутамд давтагдах болно.

Тав дахь жил гэдэг нь нэг дэх жилтэй адил байх болно. Бэлчээрлэлт болон өнжилтийн үргэлжлэх бодит цаг хугацааны урт нь тухайн бэлчээрийн хэсгийн хэмжээ, сүргийн тоо толгой, тухайн жилийн цаг агаарын байдлаас шалтгаална.

Тараан хуваарилалт

Мал сүргийг хуваарилах гэдэг бол аливаа газар нутгийг хэмжээ хэтрүүлэн ашиглахаас сэргийлэхэд их чухал байдаг. Ийм газрууд нь ихэнхдээ усны нөөц, мал амьтдын тэжээл элбэг хэсгүүд болон амьтан бөөгнөрөх төлөвтэй бусад газрууд хавиар байдаг. Бэлчээрт гаргах малын тоог буруу гаргаснаас зарим бэлчээрийг хэтрүүлэн ашиглах, зарим бэлчээрийг хэмжээнд нь хүргэж ашиглаж чадахгүй болох тийм нөхцөл байдалд хүрдэг. Хэмжээ хэтрүүлэн ашиглагдсан газрууд ихэнхдээ усны нөөц, хашаа хороо болон бусад орогнох байр савны хавиар байдаг. усны нөөцийн хавиар малын баас, өтөг бууц хуримтлагдсанаас болоод худгийн усны нөөц бохирдоход хүрдэг. Энэ нь амьтдын эрүүл мэнд, үүлдэр угсаанд нөлөөлдөг.

Хэтрүүлэн ашиглах явдлаас зайлсхийх хамгийн эрчимтэй арга бол тухайн хэтрүүлэн ашиглагдсан бүс нутгаас мал сүргээ гаргах явдал байдаг. Нөгөө арга нь гэвэл бэлчээрийг өөр байдлаар идэж ашигладаг тийм төрлийн сүргийг сонгох арга байдаг.

Тухайн бэлчээрээс гадна байгаа усны нөөцийг сайжруулах нь бэлчээрийг хуваарилах хамгийн эрчимтэй арга хэлбэр болдог. Эдийн засаг, логикийн шинжлэх ухааны үүднээс

зарим газар нутгийн ус сайжруулалтын практик үйл ажиллагаанд одоогоор хязгаар тогтоож болох юм. усны байдлыг сайжруулахад дараахи зарим нэг арга хэлбэрт багтаж болох юм. Үүнд:

- Нарны болон салхины энергийн шахалт. Алслагдсан байрлалтай газар нутгийн тухайд иймэрхүү арга хэрэгслийг зөвхөн хөрсөн дээр ус гаргаж авахад төдийгүй алслагдсан газрууд руу ус шахахад ашиглаж болно.
- Дамжуулах хоолой: Энэ нь зөвхөн бэлчээр усны нөөц хоёр өөр хоорондоо ойрхон, богино зайнд байрлалтай үед ашигтай. Дамжуулах хоолойг хүйтний улиралд хөлдөж эвдэрч гэмтэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах хэрэгтэй.

Бэлчээрлэлтийн эрч байдал

Бэлчээрлэлтийн эрч байдал гэдэг нь малый тоо ба хуваарийн хослолыг хэлдэг. Тохирсон тооны малыг тохирсон хуваариар бэлчээрлүүлэх хүртэл зөв зүйтэй ашигтай бэлчээрлэлтийн эрч хэмжээнд хүрнэ гэдэг их хэцүү байдаг. Бэлчээрт гаргах малый тоог зөв тогтоож улмаар бэлчээрлэлтийн эрч байдлыг ажиглах нь бэлчээрлэлтийн хуваарийг гаргахад тус дөхөм болдог. Бэлчээрлэлтийн эрч байдал нь малый тэжээлийн гарцад маш чухал холбогдолтой байдаг.

Бэлчээрлэлтийн эрч байдлын түвшин /бага, дунд, их/ ургамал, амьтны үйлдвэрлэлд маш ихээр нөлөөлдөг. Бэлчээр нь бага хэмжээгээр ашиглагдвал тэндхийн ургамал, өвс ногооны хувьд их сайн бат бөх үндэсний систем болон ургац, шим тэжээлийг гаргадаг /5-р диаграмыг үзнэ үү/. Их хэмжээгээр ба бага, дунд хэмжээгээр ашиглагдсан бэлчээрүүдийн ургамал, өвс ногоонд тарах өөрчлөлтийг харьцуулсныг 5.1. хүснэгтээс харна уу.

Хүснэгт 5.1. Бэлчээрийн ургамлын физиологид бэлчээрийг ихээр ашигласнаас үүсч бий болох сөрөг үр дагаврууд болон бэлчээрийг бага, дунд хэмжээнд ашигласнаар тарах нааштай эерэг үр дагаврууд.

Бэлчээрийг их хэмжээнд ашигласнаас үүсэх сөрөг үр дагаврууд	Бэлчээрийг багаас дунд хэмжээнд ашигласны дунд тарах эерэг үр дагаврууд
Нарнаас энерги авах чадвар нь буурна.	Нарнаас энерги авах чадвар нь сайжирна.
Нүүрстөрөгч/энергийг бага хэмжээгээр нөөцөлдөг болно.	Сийрэгжүүлэлт сайжирна.
ургамлын үндэс муу ургана.	үндэсний ургалтанд маш бага л өөрчлөлт орно.
үрийн гарц багасна.	ургамлын ус алдалт буурна.
Бэлчээрт идэгдээгүй ургамал өвс ногоотой өрсөлдөх чадвар багасна.	Энэ үе шатууд нь ихэнхдээ ургамал, өвс ногооны хөгжлийг өдөөж өгдөг.
Чанар муутай ургамлын бөөгнөрөл бий болдог. Энэ нь хөрсний ус нэвтрэлт хадгалалтыг багасгадаг. Хөрсийг эвдрэлээс хамгаалах, чийгшилтийг барьж байхын тулд хөрсний хучилтыг унасан навч, мөчрөөр хийж өгөх шаардлагатай. /хөрсийг манах хэрэгтэй/	ургамал, өвс ногооны өсөлт хөгжилд орон зайн болон бүтцийн байдлаар харш нөлөө үзүүлэх илүүдсэн ургамлын бөөгнөрлийг багасгах унасан навч мөчир ашиглан хөрсийг хучих нь /хөрсний маналт/ малын тэжээлийн ургамал, өвс ногоог гэмтээх, бактери, хортон шавьжид таатай орчин бүрдүүлж өгч магадгүй юм.

Бэлчээрт идэгдсэн ургамлын төрөл нь цаашид бэлчээрт ашиглагдахад ямар байх байр байдлыг тодруулж өгдөг тохиолдол элбэг байдаг. Бэлчээрт идүүлсэн ургамал, өвс ногооны дахин сэргэх чадварт тэдгээрийн үндэсний бүтэц, зохион байгуулалтын болон хүнс тэжээлийн нөөц хуримтлуулалтын хэлбэр байдал нөлөөлдөг /5.3. тоон үзүүлэлтийг үзнэ үү/. Бэлчээрийн хэтэрхий их хэмжээгээр ашиглах нь ургамлын үндэс суурь, баазыг гэмтээдэг. ургамлыг өсөлтийнх үед хадгалж байх зорилгыг гол болгон тавих хэрэгтэй. Ер нь бэлчээрийг бага хэмжээгээр ашиглах нь бэлчээрийн ургамлын тэсвэртэй байдал, төрөл зүйлийн бүтцийг сайжруулдаг. Энэ нь мал сүрэг өвс тэжээлийн шим тэжээлтэй хэсгийг идэх, ургамал өвс ногоо богино хугацаанд нөхөн сэргэх бололцоог бий болгодог.

Малын бүтээгдхүүн, ашиг шим нь бэлчээрлэлтийн эрч байдлаас бас хамаарч байдаг. Бэлчээрлэлтийн эрч их байгаа газарт малын хоорондын нөөцийн төлөө тэмцэл нь нэг малаас гарах ашиг шимийг бууруулж болдог. Дээр нь тоо хэмжээнээс илүү мал өсгөх нь усны нөөц бохирдох эсвэл хөрсний элэгдэл хэтрэх, улмаар цаашид нийт үйл ажиллагааны үр ашигт муугаар нөлөөлөхөд хүргэдэг байна. Дунд хэмжээнд бэлчээрлэлтийн эрчийг байлгахад гарах ашиг шимийг бэлчээрлэлтийн илүү их хэмжээнд ашигласан байдалтай харьцуулсныг

5.2. хүснэгт харуулж байна.

Хүснэгт 5.2.Нутах дахь Цөлийн Туршилтын Бэлчээрт бэлчээрийн эрч байдал хонины ввлийн бүтээгдхүүнд үзүүлсэн нөлөө /Холечек болон бусад зохиогчид. Бэлчээрийн газрууд 2116//.

	Бэлчээрлэлтийн эрч	
	Дунд хэмжээнд	Их хэмжээнд
Судалгаа хийсэн хугацаа /жилээр/	13	13
Дундаж хур тандас	6,7	6,7
Малын тэжээлийн ашиглалт /%/	35	60
Малын тэжээлийн гарц /фүнт/акр/	198	72
Нас бие гүйцсэн эм хонины жингийн өөрчлөлт /намраас хаврын хооронд, фүнтээр/	+9,3	+1,1
Ноосны дундаж жин /фүнтар/	10,6	9,7
Хургалалт/%/	88	79
Хозогдол /%/	3,1	8,1
Нэг нас бие гүйцсэн эм хонинд ноогдох хөхнөөс гарсан хурга /фүнтээр/	77	67
Цэвэр орлого /3,000 толгой малтай сүрэг,_\$-оор/	10,4	5,1
Цэвэр орлого/нас бие гүйцсэн эм хонь / \$-оор	3,45	1,69
Тооцоолж гаргасан цэвэр эргэлт /S/акр/	0,39	0,14

6. Дүгнэлт ба зөвлөмжүүд

Бэлчээрийн газрууд Клементшин бүлэглэлээр явах уу эсвэл тэнцвэргүй бэлчээрийн газрууд хэмээн тодорхойлогдох уу гэдэг дээр гардаг эрдэмтэн мэргэдийн маргааны иэгэн адил Говийн бүсийн бэлчээрийн муудалтийн хэмжээ маштабын талаар зарим нэг санал зөрөлдөөн байгаа нь харагдаж байна /Фернандез-Жименез, 1999/. Монголын эдийн засгийн хөгжил, түүний мал, малын бүтээгдхүүнээс хараат байгаа энэ цаг мөчид Говийн бэлчээр байнгын бууралт элэгдэлд орохуйц байгаа тохиолдолд бэлчээрийн нөхцлийн талаархи үзэл баримтлалуудын хоорондын маргаан нь болчимгүй утга учиргүй зүйл болж байна. Бэлчээрийн талаар бичигдсэн саяхны нэгэн өгүүлэлд малын тоо толгойг хэмжээ хэтрүүлэн

өсгөснөөс говь цөлийн бэлчээрт урт хугацааны бүтээгдхүүний алдагдал гарсныг гаргаж тодорхойлсон байна /Холчек, 2000/. Бэлчээрийн бусад мэргэжилтнүүд ч /Бедүнах, 1999, Хилбиг, 1995, Шиини, 1995/ бэлчээрийн нөлөөний талаар тэмдэглэж, бэлчээр хамгаалахын тулд малын тоог дахин тогтох болон бусад арга хэрэгслүүдийг санал болгосон байна. Бэлчээр болон бусад нөөцийг хамгаалахад тус дөхөм болох дараахи зөвлөмжүүдийг толилуулж байна.

REFERENCES

Adiya, P. 1999. Agronomist and Agricultural Expert, Personal Communication, November 18.

Agriteam Canada Consulting Ltd. 1997. Study of Extensive Livestock Production Systems TA No. 2602-MON. Volume II: Opportunities and Constraints Report. Submitted to Asian Development Bank, Manila, Philippines, October 1997.

Ash, A.J.; Bellamy, J.A.; Stockwell, T.G.H. 1994. State and transition models for rangelands.4. Application of state and transition models to rangelands in northern Australia. *Tropical Grasslands*, vol. 28, pp. 223-228.

Becker, Jasper. 1993. *The Lost Country: Mongolia Revealed*. Great Britain: Sceptre.

Bedunah, D.J. 1998. *Livestock Management Issues For the Gobi Gurvan Saikhan National Conservation Park*. Unpublished Consultant Report

Bedunah, D.J. 1999. *Integrated Management For Combating Desertification: Ecosystem Conditions and Livestock and Pasture Management Issues Influencing Desertification in 3 Regions of Mongolia*. Unpublished draft consultant report.

Bellamy, J.A.; Brown, J.R. 1994. State and transition models for rangelands.7. Building a state and transition model for management and research on rangelands. *Tropical Grasslands*, vol. 28, pp. 247-255.

Berge, G. 1997. *Open Access Without Tragedy of the Commons: The Case of Rangelands in Adrar of The Ifoghas In Northern Mali*. Centre for the Development and the Environment, University of Oslo.

Boyd, L. 1998. The 24-h time budget of a takh harem stallion (*Equus ferus przewalskii*) pre- and post-reintroduction. *Applied Animal Behaviour Science*, vol. 60, no. 4, pp. 291-299.

Braatz, Susan. 1992. *Conserving Biological Diversity: A Strategy for Protected Areas in the Asia-Pacific Region*. World Bank Technical Paper No. 193. Asia Technical Department Series. Washington, D.C.L The World Bank.